

ЭСХИЛ, СОФОКЛ, АРИСТОФАН



ЭРТНИЙ ГЕРЕГИЙН ЖҮЖГҮҮД





Оршил

- Эдип
Төрөлх хот маань мөргөлийн дуу
Түмний гасланд автаад байхад
Өвгөдийн залгамж залуус та нар
Хүжийн навчис гартаа бариад
Хуран чуулсны учир юу вэ?
Алдарт гэгдсэн Эдип би
Асууж лавлахаар хүрч ирлээ
Залуусыг төлөөлж өвгөн гуай та
Зорьсон хэргээ хэлж өг
Айх аюул уу, хүсэл, санал уу,
Аль нь ч байсан хүлцэн сонсьё.
Эзнээс өршөөл гуйгсдыг
Энэрэхгүй бол нүгэл биз.
- Тахилчин
Энэ нутгийн эзэн Эдип!
Энд цугларсан хүүхдүүдийг хар
Зарим маань далавчилж гүйцээгүй
Зарим маань насны туйлд хүрсэн
Зэвс тэнгэрийн тахилчин би
Залуусын сайхантай хамт ирлээ.
Цэнгэл баяраас хагацсан олон
Цэцгэн эрихээр бие чимж
Ивээлт Палладын хоёр сахнус,
Исмений тахилгын дэргэд зах дээр
Эрхэм таныг хүлээж байна.
Шуурганд нэрвэгдсэн хот маань яагаад ч
Шуугих цусан давалгаан дундаас
Тэргүүнээ өргөж чадахгүй нь ээ.
Тариа будаа хөрсөндөө хатаж
Тарга хүчээ мал сүрэг алдаж
Хүүхэд хүртэл хэвлийдээ эндэж
Хүлцэшгүй гамшиг дайрлаа.
Гай зовлон үхлийн аюул,
Хот орныг минь нөмрөөд
Гамшиг улам чангарч байна

Гал голомт хоосрон сүйдэж
Гайхал тамынх шиг уй гашуу
Газар сайгүй нөмрөн байна
Мөнх үхэшгүй дээдэстэй чамайг
Мөр зэрэгцүүлэн тавихгүй ч гэсэн
Зовлон тохиолдоход чамайгаа л гуйна.
Тэнгэрийн эзэдтэй чамайг л ярина гэж
Тэнхээ мэдэн бид бүгд залбирна.
Алх чи энд ирээд
Аюулт шулын амнаас бидний
Амь насыг аварсан биш үү,
Хэн ч тэгэхэд чамайг ер нь
Хэрэг болгож гуйж гувшаагүй
Бидний хүслийг тэнгэр таалж
Бурхан энэнийг явуулсан гэж
Бүгдээр итгэдэг болсон юм.
Эрийн дээд Эдип хаан минь
Энэрээч гэж бид чамайг гуйж байна
Төр улсын хэрэг гэж бод
Түмэн олны хүслэн гэж сана
Өмгөөлж биднийгэс авар
Өвч дэлхийд ихийг үзсэн хүн
Өөдрөг зам зааж чаддагийг
Хэн бүхэн мэднэ.
Хүний дээд хүн болсон
Хурц ухаант хаан минь
Хотоо дахин мандуул
Хотоо олондоо “аврагч” гэгдсэн
Өндөр нэрээ бод
Хаан Эдип энэ орноо
Хурмын зуур мандуулан бадруулж
Хожим нь мөхөөн унагасан юм гэж
Хэн ч ярихгүй байх ёстой.
Хотоо дахин тогтоо
Одоо ганхаж гуйвсан юм алга. Гэвч
Сайн зөн үйлсээр тэр жил
Бидэнд чи жаргал авчирсан юм.
Бүх олноо одоо ч авар
Орон улсаа захирч байя гэвэл
Олон түмнээ авар, хамгаал

Хүчирхэг хөлөг, цайз цамхаг
Хүнгүй бол юухан ч биш шүү.

Эдип

Хувьгүй үрс минь та нарынхаа
Хүсэл бодлыг ойлгож байна
Бүх нийтээрээ зовж байгааг чинь
Би сайн мэдэж байна
Хэний ч зовлон минийхтэй
Хэрхэвч дүйцэх нь үгүй.
Өөр өөрийнхөө л төлөө та нарын
Өр зүрх шаналж байхад
Хүн ард, хот өөрийнхөө төлөө
Хөөрхий би чинь тарчлан байна.
Бодоогүй биш, бодож байна
Санаагүй биш, санаж байна
Арга зам олныг хайж
Унтах нойроо ч алдлаа.
Учраа олохгүй болохоор
Уйлж бишгүй хайллаа.
Адаг сүүлд нь би
Арга зам мухардахад
Авгайнхаа дүү, Менекейн хүү Креонтыг
Төлөгч Фебтэй уулзаад
Төрөлх хотоо аврахын тулд
Өргөх алба хийх мөргөлийг
Үзүүлж харуулаад ир гэж
Өөрийн биеэр явуулсан юм.
Өнжин хонон хүлээвч
Өдий болтол алга байна.
Осол гай болов уу гэж би
Оровч гаравч энэлэн байна.
Тэр маань хүрээд ирвэл
Дээдсийн зарлиг авчирна.
Тэрний нь би биелүүлэхгүй бол
Харин бузар болно.

Тахилчин

Цагий нь олж хэллээ хаан та
Цаанаас Креонт айсуй гэж
Нааш нь дохио өгч байна.
Нэн их яарч явна гэнэ.

- Эдип Ай Аполлон их хаан минь
Ариун таны мэлмий шиг
Харанхуйг гийгүүлэх мэдээ ирвэл
Хамаг бидний баясгалан тэр ээ.
- Тахилчин Үнэхээр баяртай явах шиг байна.
Өлзийт мэдээ авраагүйсэн бол
Үндэс арвин лаврын навчаар
Өвч биеэ чимэхгүйсэн.
- Эдип Одоохон мэдээ сонсоно байх.
Хэлээч, Менекейн хүү,
Ургийн сүлбээт дүү минь
Дээд тэнгэрийн зарлиг юу вэ!
- Креонт Учиртай үг дуулж ирлээ
Урдах зам заагдсан хойно
Саар муу бүхэн
Сайн үйлээр солигдох тавилантай
- Эдип Ямар мэдээ юм бэ?
Яриач, түргэн, хэлээч
Саяын хэдэн үгнээс чинь
Баясах эмээх алийг ч бүү мэд.
- Креонт Хэлэх үгий минь сонсохыг хүснэ үү
Ярихад би бэлэн... харшид орох уу?
- Эдип Эдний дэргэд энд байж ярь,
Эгэл олны төлөө болохоос
Хар амиа бодоогүй би
Хамаг олноо бодож байна.
- Креонт Мэдэж ирснээ хэлье!
“Танай Фиван нутгийн хөрсөнд
Тавлаж үндэслэсэн бузрыг устга!
Тэгэхгүй бол зовлон арилахгүй” гэж
Тэнгэр Аполлон айлдаж байна.

- Эдип Яаж устгах юм бэ?
Яавал болох юм?
- Креонт Аллага хийсэн айхтар явдалтан
Ариун хийморьт маань бузар оруулж
Цөлж хөөх нэг арга байна
Цусыг цусаар төлүүлэх, нөгөө нэг арга нь гэнэ.
- Эдип Хэнийг хороосон юм гэнэ?
- Креонт Эрхэм таныг ирэхээс өмнө
Эзэн ширээнд Лай гэгч байж
Манай энэ нутгийг
Эзэгнэн захирч байсан гэнэ.
- Эдип Нэрий нь дуулсан л юм байна.
Зүсий нь даан ч үзээгүй юм.
- Креонт “Эзэн Лайг хороосон
Хэн ч байлаа гэсэн
Заавал өшөөгөө ав гэж
Тэнгэр зарлиг буулгалаа.
- Эдип Аль нутагт хаана байгаа юм бэ?
Өнгөрөөд удсан тэр хэргийн
Ул мөрийг яаж олох вэ?
Тун ч хүнд хэрэг ээ?
- Креонт Чармайж хичээсэн тэр хүн олно
Чармайлтгүй хүн олохгүй
Манай нутагт байгаа юм гэнэ
Магад заавал бий юм байх.
- Эдип Хээр талд уу, орон гэртээ юу?
Хүний нутагт уу? Чухам хаана
Хаан Лай алагдсан юм бэ?
- Креонт Эргэл мөргөл хийх гэж яваад
Эргэж ирээгүй хүн юм байна.

- Эдип Хааныг тэр үед дагалдаж явсан
Харц боолуудаас олодох болов уу?
- Креонт Цөм алагдсан юм гэнэлээ.
Айж мэгдэж явсаар
Амь гарсан ганц хүн бий,
Бага сага юм хэлж магад.
- Эдип Магад, магад, магадаар барах уу?
Бага ч гэсэн юмнаас
Баттай зүйлд хүрдэг биш үү?
- Креонт Хааныг дээрэмчид хороосон
Хараалт хэрэгт олон хүн оролцсон гэнэ
- Эдип Хааны биед гар хүрэх
Тийм зоригтон хаа байх вэ!
Харин муу хүн хахууль өгч
Хороолгосон байж мэдэх юм.
- Креонт Тийм ч байж болно
Ямар ч гэсэн хэцүү тэр жил
Хааны өшөөг авах хүн
Хаанаас ч олддоогүй л юм байна лээ
- Эдип Хаан нэгэнт эцэс болсон юм бол
Бас ямар гамшиг байснаас
Буруутныг олохыг бодоогүй юм бэ?
Бүр сонин хэрэг байна даа.
- Креонт Аюулт шулам Сфинксийг дарах гээд
Айхтар хэргийг мартсан гэнэ.
- Эдип Энэ хэргийг дахин би сэргээнэ
Эмгэнэлт үхлийн учрыг олох нь
Хууль зүйн хэрэг мөн гэж
Аполлон тэнгэр ч айлдлаа.
Чи ч энэнийг санууллаа.
Энэ их нутаг, тэнгэрийн төлөө
Өшөөг би заавал авна.

Та нарын хэрэгт би зүтгэнэ.
Эзэмлсэн ширээний бузрыг арилгах нь
Миний ганц ариун үүрэг.
Тэр яргачин хэн ч байлаа
Намайг бас өшөөрхөх биз.
Хаан Лаин дурсгалыг ариутгаад
Өөрөө өөрийгөө гайгаас хамгаалъя.
Ай, хүүхэд минь босоцгоо!
Бөхийлгөсөн нуруугаа тэнийлгэцгээ!
Мөргөлийн хүжсээ аваад явцгаа!
Фиван хотынхныгөө явж цуглуулцгаа!
Тэнгэрийн ивээлээр жаргалаа эдэлье!
Үгүй бол бузрын гайд дийлдэж бүрмөсөн уная.
Аль нэгий нь үзэхийн тулд
Би үнэнчээр зүтгэнэ.
Хоёрын хооронд хувь зохиол
Хэнд хэрэгтэй юм бэ!

Тахилчин

Ай хүүхэд минь босоцгооё.
Ачлалт эзний үгийг сонсох гэж цугларсан юм.
Сонсголоо бидэнд үгээ.
Зарлигаа бидэнд буулгалаа.
Замлингийн эзэн Аполлон
Бузрыг цээрлүүлэх болтугай!
(явцгаана)

Нарад
Найрал дуучид

Бадаг 1

Бурхан Зэвсийн ариун сургаал
Булт алтаар бүтсэн Пифоноос
Алдарт Фивад чи юу авчраа вэ?
Аяа, сэтгэл минь догдлон чичирнэм!
Амьдруулагч аврагч аа!
Ахин хүндэтгэн асуунам.
Огт шинэ мөргөлийг хүлээнэ үү чи?!
Олон жил өнгөрсний дараа
Бага сага шинэчлэгдэж мөргөлийг хүснэ үү?
Онцгой өөр болсон юмгүй.

Эсрэг бадаг 1 Үхэшгүй Афина, Зэвсийн охин оо
Үлэмж таныг бахдан дууднам билээ
Өргөн талбайн голд
Өндөр алдрын шилтгээнтэй
Өвч орныг минь сахигч
Таны эгч өрөвчхөн Артемидаг
Бас уринам билээ.
Тамын үхлийг ялагч гурав,
Тансаг чадалт, хосгүй харваач Фебийг бас
Таалан, таалан дууднам бид.
Энэ удаа дахин буун ирж хайрла.
Эх болсон хотыг минь та бүхэн
Энгүй зовлонгоос авраагүйсэн билүү?!
Эргээд биднийгээ хар,
Ивээл хайртаа багтаа!
Соёрх, соёрх! Дахин ир!

Бадаг 2 Ээ гуниг, гуниг
Эдлэх зовлон хэмжээгүй буюу
Өлгүйн зовлонд түмэн минь нирвэгдээд
Өөдлөхийн аргыг олгё гэтэл,
Санаанд орохгүй нь юу билээ?
Сайхан эх газар зөөлөн ч гэсэн
Хөрсөнд нь үр ургахаа байлаа.
Хөөрхөн хүүхэд төрүүлэх
Чадалгүй боллоо, бүсгүйчүүд.
Чанд далавчит шувуудаас хурдан
Шаналгах энэ зовлонгоос түргэн
Шавхагдаж гүйцэх нь, олон маань!
Үхлийн орон руу яваад байгаа нь
Даанч түргэн байна, хараач!

Эсрэг бадаг 2 Үхэгсдийг тооцох аргагүй
Өвчний мананг тархаасаар
Оршуулах зав зай ч өгөхгүй,
Энд тэндгүй хэвтэнэ.
Үзэшгүй гаслангаас салгаач гэж
Эмс хүүхэд, буурал өтгөс
Энэлэн хайлан уйлж
Эрхэм тэнгэрт хичнээн мөргөвч

Эргэж туслах хэн ч алга аа!
Ай Зэвс бурхны охин та
Аврагч болон бидэндээ ирээч!

Бадаг 3

Зэмлэл гомдлын хашгираан дунд
Зэс бамбай ч өмнөө барилгүй
Түмнийг хяргах чадалтай.
Үхлийн аймшигт зэтгэрийг
Үтэр хөөж өгөөч,
Төрөлх нутгаас зайлуулж хайрлаач,
Торох юмгүй Амфитритийн гүнд
Аюул заналаас айдаггүй
Давалгаа хаялагч гүн далайд
Даруулан живүүлж хайрлаач!
Ямар ч арга чарга үгүй боллоо.
Харанхуй шөнийн гамшгийг
Халж авсан одор нь гүйцээх юм.
Ариун бурхны сургаал, зарлиг
Алтан найдлагаар төрсөн байдаг.
Аяа, үхэлгүй мөнхийг эдэлсэн
Ачлалт тэнгэр хэлээч!
Шөнө ч, одор ч үхлээр дүүрэн
Улалзах цахилгааны чадлыг атгасан
Уужим ивээлт Зэвс эзэн минь ээ.
Дайрсан энэ гамшгийг
Далай их галаараа сөнөөн соёрх!
Мөргөн гуйнам бид
Сөгдөн эрнэм бид.

Эсрэг бадаг 3

Аяа, Ликей нутгийн хаан аа!
Алтаар бүтсэн нумаа онилж
Атаатныг дарахаар сумаа илгээ
Артемида хатагтай ч гэсэн
Ликийн ууланд давхиж явахдаа
Төмөр савтай гал дөлөө
Төө зайгүй улалзуулж хайрла.
Нутаг газартай минь нэрээ холбосон
Вакх таныгаа ч бид дуудъя
Нүнжигт алтан боолттой,
Сархад зооглон улаа бутарч,

Сайхан царайт Менадуудаа дагуулсан
Вахх таныг урин дуудъя
Галт бамбараа бидэнд ойртуулж
Гай таригч адгийн бурхдыг
Бидэнтэй хамт ниргэлцэг!
(Эдип ирэв)

Эдип

Та нар тэнгэрт мөргөсөөр үү?
Миний хэлснийг биелүүлбэл
Тавилан ерөөлөө хөнгөлж
Тэтгэмж хамгаалал олно гэдэгт
Тээнэгэлзэх хэрэг байхгүй
Явган яриа, болсон хэрэг
Надад хамаагүй боловч
Онцолж хэлэх юм бас байна.
Уг хэргийн ул мөр
Үгүй байгаа болохоор
Ганц би яаж ч чадахгүй.
Угаас би энэ нутгийн
Уугуул иргэн нь биш
Тэгээд Кадмын охид, хөвгүүдэд
Хэлэх үгээ хандуулж байна.
Хаан Ланг хороосон
Хүнийг мэдсэн байвал
Хүлцэх айх юмгүйгээр
Надад бүгдийг нээж хэл
Өөрөө гар далайсан байлаа ч
Эмээх хэрэг байхгүй
Муу юм би хийхгүй,
Ердөө л нутгаа тэр хүн
Хаяад явах хэрэгтэй болно.
Харин хүн хороосон байгаад
Та нар түүнийг мэддэг юм бол
Даруй надад айлтга!
Тэгсэн хүнд харамж огно.
Тийм хүнд ивээл хайрлана.
Ямар ч гэсэн өөрийгөө хаацайлах,
Ялаас нөхрөө зайлуулах гэж
Хэлж чадахгүй нуух юм бол
Хэлэх үг надад бас байна.

Эрх нь миний гарт байгаа
Энэ орны хаана ч гэсэн
Хилэнцэт тэр хүн байгаа бол
Хэн нь ч гэсэн гэртээ орогнуулж
Түүр байтугай үг сольж болохгүйг
Өнөөдөр би зарлигдлаа.
Мөргөл залбиралд оруулж болохгүй,
Мөнхийн рашаанд ойртуулж болохгүй,
Хотыг нөмөрсөн аюул гамшгийн
Ганц үндэс нь тэр хүн болохоор
Хөөж зайлуулах хэрэгтэй билээ
Аполлон бурхан ингэж заалаа.
Авралт тэнгэрийн соёрхлыг биелүүлж
Хороогдсон хааны өшөөг авах
Хувь тавилан надад оногдож.
Хараал хүрэг яргачинд!
Хар хэргийг үйлдсэн
Ганц ч хүн бай
Олон ч хүн бай
Жигшүүртэйгээр амьдраг!
Тэр хүн хараал идэг!
Тийм хүн гэр оронд минь
Миний зөвшөөрлөөр зочилсон байвал
Хамгийн түрүүнд би
Хилэнц нүгэл хийсэн гэж
Цээрлэл хүлээхээ тангараглая.
Тэнгэрийн хилэнд дайрагдаж
Тэсэшгүй зовлон хүлээж байгаа
Намайг, бүхнийг, нутгаа бодож
Зарлигийг биелүүлэх хэрэгтэй та нар
Зарлиг буугаагүй байсан ч гэсэн
Ухаант тэр хаан эзнээ
Ертөнцөөс хальсан тухай
Эрхбиш нэг юм санах л байсан байх.
Ингээд хайцгаа, эрцгээ!
Хаан эрхийг нь Лаигаас залгаж
Хатан гэргий, хамаг бүхний нь авснаас хойш
Хүүхдий нь би хүмүүжүүлэх байлаа.
Үрийн заяагүй байж, тэр хүн!
Үйл гэдэг хатуу байж, энэ хүнд.

Эцгээ гэж Лаиг би үзээд
Хүүхдий нь оронд түүнийг өмөөрч
Лабдагийн хүү, Полидорын ач,
Агенор өвөгтэй, Кадм эцэгтэй
Энэ хүнийг хороосон бузар яргачинг олж барихад
Хүчээ бид хайрлахгүй.
Үг зөрсөн хүний
Газар нь тариа ургахгүй,
Гэргий нь хүүхэд төрүүлэхгүй,
Бидний хараалд сөнөг!
Бусдын гарт орвол
Бүр аймшигт үхлээр үхэг гэж
Бурханд би залбирна.
Миний зарлигийг хүлээсэн
Кадмийн үр сад та нарыг
Бурхад үүрд хамгаалах болтугай!
Үнэн ёс та нарыг сахих болтугай!

Найрал дуучид Таны тангарагт тангарагаар хариулъя.
Лаиг би алаагүй, ялт хүнийг ч мэдэхгүй
Гэвч буруутныг Аполлон заан соёрхож
Бидэнд тусална, хаан минь.

Эдип Чиний хүүрнэл зөв байвч
Хүслийнх нь эсрэг бурхдыг
Хэн ч хүчилж чадахгүй.

Найрал дуучид Дээр ч бол уу? Өөр юм хэлье.

Эдип Дээр дор нь хамаагүй
Тустай л бол хэлээд бай!

Найрал дуучид Бултыг захирсан Аполлон шиг
Бүхнийг зөгнөн харах чадалтай
Өвгөн Тиресий гэгчээс хаан минь
Үнэнийг мэдэж болно шүү!

Эдип Үүнийг сонсоод би яарсан.
Креонтын зөвлөсөн ёсоор
Өвгөнийг авчруулахаар хоёр элч довтолгосон юм.

Одоо хүртэл алга байгаад
Гайхаш тасарч байна.

Найрал дуучид Эртний яриа бас байдагсан...

Эдип Юу гэж? Үг бүрийг дуулах хэрэгтэй.

Найрал дуучид Хааныг аянчид хороосон юм гэдэг.

Эдип Гэрчлэх хүн байхгүй
Би ийм үг дуулсаан

Найрал дуучид Айх эмээх гэж бий л бол тэр хүнд
Аймшигт зарлиг буулгаснаас тань
Амь тавих шахан зүрхшинэ биз.

Эдип Хийхдээ зүрхтэй бол
Хэлэхээс айдаггүй юм.

Найрал дуучид Бүхнийг харж мэдэх чадалтай
Үнэнийг хэнээс ч илүү мөрддөг
Өвгөн гуайг аваад ирлээ, ашгүй!
(Тиресий орж ирнэ)

Эдип Тэнгэр газрын гүнд нууцлагдсан
Тэмтрээд олдохгүй юм бүгдийг
Тэнүүн оюунаараа тусган мэдэгч
Тэргүүн хүн Тиресий та!
Мэлмий тань харанхуй ч
Сонор тань ариухан!
Манай хотод дайрсан гайг
Магадалж дуулаа биз та!
Өршөөн тэтгэч маань ганц та юм гэж
Өнөр бид чинь найдаж байна
Элч нар танд учрыг нь
Эрэмбэлж хэлээгүй байж болно.
Хааныг хөнөөгчийг олоод
Хороох юм уу, Фивээс хөөвөл
Дайрсан зовлон арилна гэж
Аполлон тэнгэр айлдсан билээ.

Та минь ингэхлээр одоо
Тааваараа нисэгч шувуудаас асууж,
Таалалдаа бясалгаж шоо орхиж,
Яаж ч байгаад гэсэн
Явдал байдлыг тунгааж үзээд
Өөрийгөө, намайг, Фивээ авар!
Аллага хядлагын бузарт нэрвэгдсэн
Ард олноо ариутга, тэтгэ!
Бид таны эрхшээлд байна.
Болох чадахаараа хүнд туслахаас илүү
Бахдам сайн үйл үгүй дэг.

Тиресий Аяа хөөрхий, мэдэж байгаа юм
Аюулд хүргэх нь хэцүүеэ.
Санаж байсан тэр юм минь ч
Санаанд одоо үгүй болжээ.
Түүнээс бус би ирэхгүй байлаа.

Эдиш Юу болох нь энэ вэ?
Юунд ингэтлээ зовов оо та?

Тиресий Намайг явуулж хайрла
Тус тусынхаа зовлонг
Үүрч явах нь ч амар биз.

Эдиш Үгний чинь учир олдохгүй нь...
Хариулахаас татгалзаж байгаа болохоор
Халуун элгэн Фив нутагтаа
Хайргүй юм шив та.

Тиресий Өөрөө өөртөө хэрэггүй юм
Үглэж хэлээд байна даа чи!
Би мэддэгээ хэлбэл
Яг л ийм болноо...

Найрал дуучид Мөнх тэнгэрийг санаж
Мэддэгээ битгий нуу.
Хэлээд биднийг амраагаач гэж
Хөлд чинь сөгдөж мөргөс бид.

- Тиресий Галзуу өвчин тусав уу, та нар!
Санаанд минь байгаа... чиний зовлонг
Яасан ч би хэлэхгүй
- Эдин Яана гэнээ? Мэдсэн ч хэлэхгүй гэв үү?
Биднээс урваж хотоо сүйрүүлэх нь үү?
- Тиресий Өөрийгөө ч би зовоохгүй
Чамайг ч тарчлааж хэрэггүй.
Намайг зэмлэж яах нь вэ?
Нэг ч үг би хэлэхгүй
- Эдин Хадыг ч болов уурлуулж мэдэх
Адгийн муу амьтан байна чи
Хэлэх үү, үгүй юу, мэддэгээ?
Хэдэрлээд байя гэж бодож байна уу?
- Тиресий Өөрийн зангаа хянахгүй байж
Намайг зэмлэж хараана гэнээ.
- Эдин Төрөлх хотоо доромжлуулчихаад
Дуугүй байх хүн олдох уу?
- Тиресий Би дуугүй байлаа ч гэсэн
Бүх юм заавал илэрнэ.
- Эдин Тэгэх тусам чи над хэл.
- Тиресий Нэмж нэг ч үг дуугарахгүй
Ниргэтэл уурсах нь чиний эрх.
- Эдин Уур хүрч байна гэж жигтэйхэн
Ухаанд бодогдсон бүхнээ би
Ил хэлчихье, мэдэж ав.
Уул хэрэгт та холбоотой,
Гар дүрээгүй ч гэсэн
Санаа нэгдсэн нь лав.
Нүд чинь хараатайсан бол
Чивэлт алаач та байна гэж
Чиний үнэнийг хэлчихмээр байна.

- Тиресий Уухай тийм үү?
Надад тулгасан ялаа
Өөртөө хүлээвэл дээр биш үү.
Эд ч тэр, би ч тэр
Энэ хэрэгт хамаарахгүй
Нутгаа бузарт авахуулсан
Нүгэлт хүн бол чи
- Эдип Ийм үг ичгүүргүй хэлчихээд
Ялгүй өнгөрнө гэж бодно уу?
- Тиресий Шийтгэл надад оногдохгүй
Үнэн явдгаараа би хүчтэй.
- Эдип Хэлсэн энэ үгэндээ
Шийтгэл хүлээхгүй гэж санана уу!
- Тиресий Үнэн, хорвоод байгаа л бол,
Үнээ барчихаагүй л юм бол
Би юунаас ч айхгүй.
- Эдип Үнэн хорвоод байгаагаас биш
Чиний дотор байхгүй
Хараа, сонор ухаан сэтгэл
Цөм чамаас зайлжээ өвгөөн.
- Тиресий Аз муут хүн чи байна.
Намайг зэмлэсэн бүхнээр
Чамайг удахгүй хүн бүр зэмлэнэ.
- Эдип Мөнхийн харанхуйд уургалагдсан
Мулгуу өвгөн чиний хараал
Саруул гэгээ харагч хэнд ч
Юу ч болохгүй нь магад.
- Тиресий Тийм ээ, миний гарт үхэх
Тавилан чамд байхгүй.
Надтай, надгүй Аполлон
Цээрлүүлж чамайг шийтгэнэ.

- Эдип Чиний өөрийн санаа юу?
Креонтын бузрын бодол уу?
- Тиресий Чиний дайсан Креонт биш
Өөрөө өөртөө чи дайсан!
- Эдип Ээ тэнгэр, хөрөнгө мөнгө, эрх ямба гэдэг
Энэ дэлхийд гамшиг юм
Амьдын атаа тэмцэл дундаас
Энэ л хамгийн айхтар юм.
Эрх мэдэлтэн болох билээ гэж
Энэлж горьдож явдаг хүн байх нь.
Хотыг захирах хаан эрхийг
Хэрхэвч би гуйж аваагүй.
Ард олны хүссэнээр
Аяндаа би ширээнд суусансан.
Гэтэл Креонт, хэзээний миний дотнын нөхөр
Хамаг эрхийг авах гэж
Хар санаа өвөрлөж
Далдыг мэдэхдээ сохрын сохор,
Муу санаанд хараа нүдтэй,
Хорон сэтгэлт, хуурамч өвгөнийг
Над руу түлхэж явуулдаг байж.
Далдыг мэддэг чадал
Чамд хэзээ байлаа.
Араатан шулмаас олноо аврах
Оновчтой үг чи олж хэллүү?
Хэн ч оньсыг нь тааж чадахгүй байж билээ.
Мэргэлж мэдэх хэрэгтэй байсан юм.
Тэгэхэд чи шувууны нисэлтээр ч
Тэнгэрийн совин зөгнөлөөр ч
Юу ч олж хэлж дийлээгүй. Гэтэл
Юм мэдэхгүй Эдип ирж
Шулмын оньсыг таагаад
Тэгэхдээ шувуугаар шодоогүй
Тэрнийг номхруулж огсон биш үү?
Одоо намайг зайлуулж аваад
Креонтын ширээнд ойртох нь уу?
Та хоёр хоёулаа гэмшинэ.
Ариун үнэнийг бузарлагч чи ч

Оногдох хувиа хүртэнэ...
Үгнэний чинь албадаад хэлүүлэхсэн
Өндөр насы чинь би бодож байна.

Пайрал дуучид Уурын мунхгаар муу үг хэлэв биз энэ.
Та ч бас тэгэв биш үү, хаан минь
Дээдсийн зарлигийг хэрэгжүүлэх нь
Юунаас ч илүү биш үү, бидэнд

Тиресий Хаан эрх чамд байвч
Хариуцах эрх надад байна.
Хаанаас дутуугүй мэдэлтэн би.
Локсий хааны шадар юм би.
Креонтын ивээл ч надад хэрэггүй
Сохор гэж намайг чи хараавч
Өөрөө нүдтэй атлаа
Хаа байгаагаа
Хэнтэй ханилснаа
Гамнигт үйлгээ чи харахгүй байна.
Язгуур угсаагаа мэдэх үү дээ?
Эндэж үрэгдсэн, амьд байгаа
Элгэн садан төрөлдөө чи
Эгнэлгүй дайсан болсноо
Эгээ л бодохгүй байгаа биз.
Ээж, аавынхаа төлөө чи
Хоёр давхар зовлон эдэлж
Хол цөлөгдөхөө ч мэдэхгүй байгаа.
Өноо нүд чинь гэгээ харж байвч
Удахгүй харанхуй болно.
Сайхан явсны эцэст
Ерийн буудалд ирээд
Хэнтэй ханилснаа мэдмэгц
Кифероны аль ч өнцөгт
Чиний уйлаан сонсогдоно.
Оор зовлон олон тулгарахыг
Чи огт зүүдлэх ч үгүй байна.
Хүү нь, нөхөр нь, хүүхдэд нь бол
Ах нь гэдгээ чи ойлгохгүй байна.
Креонт бид хоёрын үгийг
Яаж ч гүтгэсэн чиний дур.

Үхлийн хэцүүг сүүлд эдлэх
Чамаас өөр хүн байхгүй шүү.

- Эдип Занаг зүхэл тэрнээс гарав уу?
Хараал хүрэг тэрэнд,
Зайл чи эндээс
Миний гэрээс шалав яв.
- Тиресий Чи өөрөө дуудаагүй бол
Би юунд ирэх билээ.
- Эдип Галзуу хүн шиг ярих юм гэж
Даанч би бодсонгүй.
Мэдсэнсэн бол юунд дуудах вэ?
- Тиресий Чинийхээр бол би галзуу байна уу?
Эцэг эх чинь намайг
Мэргэн ухаантай л гэдэг байлаа.
- Эдип Хэн гэнээ? Байзаач, чи!
Хэн намайг төрүүлсэн гэж?
- Тиресий Өнөө чи төрснөө мэдэж
Үтэр түргэн үхэх болно.
- Эдип Оньсого шиг юм ярьж байна чи
- Тиресий Оньсогогт нууцыг таахдаа
Мэргэн бишсэн билүү чи?
- Эдип Мэргэнээрээ өөдөлсөн юм би,
Чи тэрний минь шоолж байнаа?
- Тиресий Хэт ондорт гарсан чинь
Чамд үхэл болно.
- Эдип Энэ хотыг би аварсан
Өөр бодох юм надад алга.
- Тиресий Явлаа. Хүү минь намайг хөтөл.

Эдиг Аваад яваг, надад л сайн биз.
Хүлцэж тэвчихийн арга алга.
Явчихаар чинь ядаргаа гарна.
(явцгаана)

Найрал дуучид Аймшигт хэргээр гараа цусадсан
Бадаг 1 Аль газрын хэн юм болоо?
Алсын Дельфийн хад
Хэний нэрийг дурдаа бол оо?
Зевсийн хүү, аюулт хүчнүүд
Зэрвэс андуурдаггүй Керүүд
Гал бадарсан аянга ниргүүлж
Гарах зайгүй дайрахад нь
Салхинаас хурдан морьдоос дутуугүй
Дүүлэн давхиж одсон юм байж.

Эсрэг бадаг 1 Цаст Парнасын оройгоос
Зарлиг бууж ирэв биш үү?
Зальхай явдалтанг даруй барьж гэнэ.
Нэр ус ч байхгүй юм.
Уйтгар гунигаар сэтгэлээ дүүргэж
Ой, тайга, хавцлаар яваа биз.
Унасан газрынхаа оноосон
Үйл тавиланг хөнгөлөх гэвч
Өнөө айхтар муу заяа нь
Дээгүүр нь улам нягтарч байнам.

Бадаг 2 Өндөр настны хэлсэн үг
Үнэхээр битүү утгатай байнам.
Үнэн гээд буруутгаж болохгүй нь
Юу хэлэх вэ? Сэтгэлд түгшүүр дүүрэн.
Урьдын явдал ч харанхуй,
Ирээдүйн хэрэгч бүрэнхий.
Лабдакийнхны угсаа удам
Полибаас үндэслэн төрөгсөд
Бие биедээ гаслан учруулдаг гэж
Хэзээ ч би дуулаагүйсэн.
Эдипийг буруутгах учир
Ердөө ч алга байх шиг,
Хаан Лаиг хороосон хэн бэ?

Хэнээс өшөө авах вэ?
Даанч бас мэдэх юм алга.

Эсрэг бадаг 2 Гэвч Зэвс, Аполлон хоёрын
Гэгээн ухаан хурц болохоор
Хүний хийж байгаа үйл бүхнийг
Тунгааж мэдээд л байдаг.
Харин би мэдлэгээрээ бусдаас
Тийм ч доогуур орохгүй байх.
Хүн хүний мэргэн ухаан
Өөр өөр байдаг л даа.
Гарцаагүй баримт гаргахаас нааш
Эдишийг яасан ч буруутгахгүй.
Түмэн олны харсаар байтал
Далавчит шулам тэр өдөр
Энэний өмнө бууж өгөх дээр
Эдишийг цөмөөр хүлээн ухаарч
Фив маань гавьяагий нь үнэлж билээ.
Үгүй, гэмт хэрэг Эдип үйлдсэн гэж
Би хэзээ ч итгэхгүй билээ.
(Креонт ирнэ)

Креонт Нутаг нэгт түмэн минь ээ.
Хаан Эдип намайгаа
Хар муу хэрэгт хардаж байна гэнэ.
Тэсэх аргагүй болоод
Та нартаа ирлээ би.
Олны гамшиг зовлон дунд
Өөрт нь хор хүргэх гэж
Үг, үйлээр оролдож байна гэж
Намайг муу санаж байгаа бол
Амь амьжиргаа надад хэрэггүй,
Ийм алдрыг би хүлээхгүй,
Эгэлгүй энэ мэт яриа,
Үйлсийг муугаар хөтөлнө.
Үнэндээ тусгүй юманд хүрнэ.
Хотын олон та бүгдээрээ
Хорлогч гэж намайг тооцвол
Тун ч тусгүй юм болно!...

- Найрал дуучид Учры нь тунгааж бодолгүй
Унтууцсан сэтгэлийн уршгаар
Ийм яриа үүсгэлээ.
Тэгсэн нь ер эргэлзээгүй.
- Креонт Мэддэгээ ярьсан өвгөнийг
Миний үгээр худал хэллээ гэж
Мэтгэж уурлаж байх юм.
- Найрал дуучид Тэгж хэлэх нь хэлсэн.
Цаад санаагийн нь мэдэхгүй байна.
- Креонт Хүн сэтгэлээ алдсан амьтан
Ухаан саруул байхдаа
Намайг тэгж муутгах гэж.
- Найрал дуучид Тэгвэл мэдэхгүй байнаа бид!
Хаадын хэргийг мэдэх биш.
Цаана чинь өөрөө гараад ирлээ.
- Эдип Юу вэ? Чи юу? Энд ирж яаж зүрхлэв ээ?
Хааныг хороож алсан,
Ширээ рүү одоо гэтсэн
Гарцаагүй хулгайч мөн байж
Ичих ч үгүй гэрт минь орно уу чи?
Тэнгэрийг барьж гуйя? Үнэнээ хэл!
Энэ хэргийг үйлдэхээр шийдэхдээ
Мангуу, хулчгар гэж намайг бодов уу?
Хар явдны чинь мэдэж харахгүй,
Биеэ хамгаалж тэмцэхгүй гэж санав уу?
Санаа нэгт нөхөдгүй,
Сан хоронго, мөнгөгүй байж
Хаан эрхийн төлөө тэмцэх нь
Харалган тэнэг хэрэг биш үү?
Талдаа нөхөдтэй, цаанаа мөнгөтэй байж
Ийм ажил сэдцэг байх шүү.
- Креонт Хэлсэн үгэндээ тайлбар сонсож
Маргах үндсийг нь дуулаад
Хүний явдлыг цэгнэж бай!

- Энн Яриа чинь яруухан, би мэднэ.
Хүлцэшгүй дайсан минь чи болохоор
Чиний үгийг би сонсохгүй.
- Крсонт Үгүй ээ, сонс. Ийм байна шүү...
- Энн Би буруугүй гэж битгий үглээрэй.
- Крсонт Өөрийн бодсон өөртөө зөв гэж байхгүй гэвэл
Ухаангүй хүн чи байна.
- Энн Ураг садандаа хор хүргэх нь
Гэм ялгүй гэж санадаг бол
Засаршгүй буруутан би болно.
- Крсонт Энэ үг чинь зөв байна. Гэхдээ
Надаас болж ямар хохирол хэнд учраав?
- Энн Саяын тэр өвгөнийг авчруул гэж
Чи намайг ятгасан!
- Крсонт Одоо ч би өвгөний талд шүү.
- Энн Олон жил өнгөрсөн үү? Хаан Лаи...
- Крсонт Хаан Лаи?...Би ойлгохгүй байна.
- Энн Хортны гарт үрэгдсээр ч юм уу
Сураггүй алга болсоор удав уу?
- Крсонт Тэрнээс хойш олон жил сар өнгөрсөн!
- Энн Тэр үед энэ өвгөн чинь
Бас л цуутай байгаа юу?
- Крсонт Цуутайгаар барахгүй
Үнэн мэргэн, хүндтэй ч байсан.
- Энн Намайг дурсдаг байсан уу?

- Креонт Тэрнийг би харин дуулаагүй юм.
- Эдип Хороосон хүнийг нь эрсэн бил үү?
- Креонт Зөндөөн эрээд олоогүй юм.
- Эдип Тэр үед энэ өвгөн чинь
Яагаад дуугүй байсан билээ?
- Креонт Мэдэхгүй, мэдэхгүй болохоор би дуугарахгүй.
- Эдип Мэдэх юмаа харин
Мэтгэлгүй үнэхээр хэлнэ дээ...
- Креонт Юу тэр вэ? мэдвэл нуухгүй.
- Эдип ...Үнэндээ та хоёр хуйвалдаагүй бол
Хааныг хороосон муухай хэргийг
Надад тулгахгүй байсан юм.
- Креонт Өвгөний үгний учрыг чи л мэдэж байгаа байх.
Өөрөө харин чи, миний асуултанд хариул.
- Эдип Асуу намайг буруутгах юм чамд олдохгүй.
- Креонт Миний эгчийн нөхөр чи мөн биз дээ?
- Эдип Юу асуух чинь энэ вэ? мөн, тийм.
- Креонт Фивийг эзэмших эрхийг нь
Чи хуваалцдаг биз ээ.
- Эдип Хүссэн хүслий нь цөмийг биелүүлдэг.
- Креонт Гурав дахь хүн би
Эрхээр чацуу байх ёстой биш үү?
- Эдип Уухай, ингээд санаа чинь илэрлээ дээ.

Үгүй ээ. Миний хэлсэн үгний учрыг
Ухаж сайн бодоорой.
Үргэлж айж байх тавилантай
Хаан эрхийг хэн хүсэх юм бэ?
Эзэн ширээнд суухыг
Би хэзээ ч бодоогүй!
Харин эрх ямбаны хэсэг нь л
Надад байвал сайхаан.
Ухаан санаа эрүүл хүн бүр
Над шиг ингэж бодлно.
Чиний өглөгч хандлагыг
Аймшиггүй би хүлээдэг.
Харин өөрөө хаан сан бол .
Юу хүссэнээ хийхгүй л байхсан.
Хаан ширээг эзлэх нь
Эрх чөлөөгөө эдлээд
Лятай тайван амьдрахаас минь
Илүүтэй байх гэж үү?
Хамгийн дээр ганцаараа гарчихаад
Яахаа мэдэхгүй бэмбэгнэж байх нь
Надад илүү байх гэж үү?
Энэнээс дээгүүр тохь тавыг
Эрж явах тэнэг хүн
Эгээ ч би биш ээ.
Ухаан минь тэтлээ мунхраагүй,
Хүн бүр надад сайныг хүсч байна.
Иргэн бүр намайг хүндэлж байна.
Хаан танд гуйлт дамжуулаач гэж
Над дээр тэднийг ирэхэд нь
Би аваад дамжуулдаг
Болохоор эрэлтийг нь дэмжиж байгаад
Бүтээгээд өгдөг ч олон бий.
Ийм байгаа амьдралаа
Юугаар би солих юм бэ?
Өөр над юу ч хэрэггүй.
Ухаан санаа минь төөрөхгүй
Тийм хэрэг би хийх ч үгүй.
Бусдыг тэгэхэд ч дэмжихгүй
Бурхдын буулгасан зарлигийг
Зөв дамжуулсан эсэхийг минь

Дэлыфээс очиж асуу та?
Мэргэч овгөнтэй хуйвалдсан гэдэг
Гарцаагүй баримт олбол
Намайг дор нь хөнөө!
Өөрөө өөрийгөө ч би цээрлүүлнэ.
Хорг мууг ачтан гэж
Ариун сэтгэлтэнг хортон гэж
Хамаагүй нэрлэх тусгүй учраас
Хардсан даруйдаа ял тулгах
Талаар дэмий хэрэг биш үү.
Үнэнч нөхрөө түлхэх гэдэг
Насан туршийн үнэт юмаа
Гээж алдсантай адил болохлоор
Гэмших цаг чамд ирнэ.
Үнэнч хүнийг танихад
Удаан хугацаа хэрэгтэй.
Бузар санаатныг ойлгоход
Ганц өдөр л хүрэлцээтэй.

Найрал дуучид Ухаантай хүнд бол энэний үг зөв.
Түргэн шийдсэн юм найдваргүй байдаг.

Эдиг Хар санасан дайсан яарч байхад
Би ч бас түргэвчлэн арга олох хэрэгтэй.
Намайг удаад байвал
Муу санаатан хүссэндээ хүрээд
Би юу ч үгүй хоцорно шүү дээ.

Креонт Чи яах гээд байгаа билгээ?
Намайг хөөх гээд байна уу?

Эдиг Хоөгдөх чамд багадна.
Алтан амийг чинь хорооно.
Атаархах сэтгэлд баригдвал
Яадгийг чи мэдэрнэ.

Креонт Буцалтгүй ингэж шийдсэн бол
Надад итгэхгүй байгаа юм аа?

Эдиг Тийм, би чамд яасан ч итгэхгүй.

- Креонт Ухаан санаа чинь самуурч!
- Эдип Өөрийн санаа минь өөртөө зөв!
- Креонт Миний хэлж байгааг бас бодолцооч.
- Эдип Чи урвагч!
- Креонт Ухаан чинь нээрээ самуурчээ!
- Эдип Эрх мэдэл миний гарт шүү.
- Креонт Буруугаар эдлэгдсэн эрх мэдэл
Хэнд ч хэрэггүй болдог юм.
- Эдип Ай тэнгэр, Фив минь
- Креонт Чи эзэгнэх мэдэлтэй гэхэд
Би ч Фивдээ бас эрхтэй.
- Найрал дуучид Дээдэстэн, большгооно уу.
Хатан Иокаста ордноосоо, ашгүй
Гараад нааш ирлээ.
Маргааныг аядуулж таслах биз.
- Иокаста Ухаан муут азгүй амьтад
Улаа шагайлцан хэрэлддэг биш үү
Улс хот чинь даяараа
Уйлаан, гасланд автан байхад
Хувийн ошоо хонзонгоор
Идэлцэж байх чинь ичгүүр биш үү?
Эдип гэртээ морил, Креонт чи ч бас яв.
Жижиг уур унтууцлаа
Жигдрүүлж засаж авцгаана биз.
- Креонт Эгч минь соёрх, Эдип намайг
Адгийн муугаар цээрлүүлэх гэнэ.
Нутгаас хөөх ч юм байх.
Үгүй бол цаазлах юм байх.

- Эдип Ийм байна аа, хатан минь
Намайг сэмхэн хөнөөх гэснийг нь
Би илрүүлж мэдээд байна.
- Креонт Намайг зэмлэж байгаа зэмлэл чинь
Үнэн л байдаг юм бол
Насаараа би зовж үхье.
Хүн бүхний хараал идье.
- Иокаста Мөнхийн тэнгэрийг санаж
Ариун энэ тангаргийг нь бодож
Өмнө чинь байгаа намайг, эднийг нигүүлсэж
Энүүнд итгээч, Эдип ээ
- Бадаг 1
Найрал дуучид Мөргөө, үгий нь дага!
Бодож санаад бууж өг!
- Эдип Юу гэж бууж өгөх юм бэ?
- Найрал дуучид Хаан аа, төрөлхийн шударга билээ энэ.
Харсаар байтал тангараг өргөлөө.
Мөргөө, гуйя, уучил энэнийг!
- Эдип Юу гуйснаа мэдэж байна уу чи?
- Найрал дуучид Ойлгож байнаа.
- Эдип Хэл!
- Найрал дуучид Таны дүү, ариун үнэнч
Дэмий яриа сонсон дуулаад
Нөхрөө яаран буруутгаж болохгүй.
- Эдип Чиний санааг би ойлголоо
Намайг, үгүй бол хороох,
Үгүй бол хотоос цөлөх гэж
Бодсон бодол чинь ил байна.

Бадаг 2

Найрал дуучид Бишрэл багатныг дагуулагч Гелий

Бидний үгийг сонсон хайрла
Хэрэв муу юм бодсон бол би
Бурханд буруу харагдан
Нөхөддөө түлхэгдэж гологдон
Ичгүүртэйгээ үхье би.
Үгүй, эх болсон нутгаа
Гамшгаас салгахын төлөө
Амьд байх ёстой.
Улирч өнгөрсөн зовлон дээр
Одоогийнхыг нэмэн өсгөвөл
Юу болох вэ, яах вэ?

Эдип

Эцэстээ би хөөгдлөө ч
Сүүлдээ би цаазлагдлаа ч
Буруут энэний үгэнд
Бууж өгч байгаа юм биш,
Чиний өрөвдмөөр үгэнд
Хайлж байгаа минь энэ.

Креонт

Уур хилэн тань хэвээр байна.
Тайвшраад ирэхээрээ гэмшинэ та
Уул морийг зовооно
Уур биеийг зовооно.

Эдип

Зайлна уу, үгүй юу чи?

Креонт

Та намайг хүн биш гэж тооцовч
Эдэндээ би хэвээрээ
(явна)

Найрал дуучид

Аваад ордондоо орохгүй
Юундаа удаа вэ, хатан аа?

Иокаста

Урдаар хамаг учрыг нь олъё.

Найрал дуучид

Ярианаас болж сөрдэлцсэн юм...
Явгуу хоронд ялагдаж

Худал юмс хэлэлцсэн бол
Гүтгэлэг гэдэг хүнд юм шүү.

Иоскаста Хэрэлдсэн юм уу?

Найрал дуучид Хэрэлдсэн

Иокаста Юу гэж тэр вэ?

Найрал дуучид Олны гамшиг хэцүү энэ үед
Зорж муудалцсан тэдний үгийг
Дахин давтах нь илүүц биш үү?
Бид тэгж санаж байна.

Эдиш Миний бодлыг няцаах гэж үү?
Үнэнч ёс гэж ийм юм бий.

Найрал дуучид Хаан минь сонсон соёрх
Халамжит таныг зэмлэх
Санаа бидэнд төрвөл
Саар зовлонг эдлэх
Зовлого болон хувиръя гэж
Тангаргаа өргөсөн биш үү бид?
Тэсэхэд бэрхтэй гаслангаас
Тэнүүн нутгий минь та
Тэр жил аварч гаргаад
Зөв замд нь хөтөлсөөн.
Хойшид та минь хэвээр
Улсы минь залж түвшитгэ!

Иокаста Дарагдаж болшгүй уур хилэн
Яагаад төрөх болов?
Наддаа хэлээч, би гуйя.
Найман тэнгэрт мөргөө.

Эдиш Сэтгэл булаасан чамайгаа
Хэнээс ч илүү би хүндэтгэнэ.
Хамаг хэрэг Креонтод
Тэрний муу санаанд байна.

- Иокаста Хэлж нээж болохоор юм бол
Хэрүүлийн учир юунд вэ?
- Эдип Хаан эзний амийг
Би хороосон юм гэнэ.
- Иокаста Өөрөө тэгж бодоо юу?
Хүн тэрний нь хэлүүлээ юу?
- Эдип Зальхай өвгөнөөр дэмий юм яриулчихаад
Өөрөө хамаагүй юм гэнээ.
- Иокаста Эзэнтэн юм бодохын хэрэггүй
Эрдэм номонд хичнээн гаргууд ч
Ижилгүй мэргэн нэртэй ч
Юу болохыг урьдаас таадаг
Чадал хүнд хараахан байхгүй
Товчхон баримт би энд айлтгая
Тэнгэрийн зарлиг тэр жил
Лаи хаанд ингэж буулаа:
Феб оороо ч хэлгүү?
Тахилчингаараа ч дамжууллуу?
Ямар ч гэсэн хаан Лаийн амийг
Бид хоёрын дундаас төрсөн хүү
Хөнөөж хорлоно гэсэн юмсан.
Гэтэл сургий нь дуулахад хаан
Гурван замын уулзвар дээр
Үл танигдах дээрэмчдийн гарт
Өртөж насан эцэс болсон юм.
Нялх үрээ төрмөгц гурав дахь өдөрт нь
Гар, хөлийг нь боогоод
Хүний хөл байтугай дуу хүрэхгүй газар
Ууланд аваачиж хаяулсан юм.
Ингэж Аполлон бурхны мэргэ толөг биелээгүй юм.
Хүү нь ааваа алаагүй, Лаи хүүдээ алуулаагүй.
Гэсэн ч тэр маань үргэлж
Эмээж явдаг байсан юм.
Ер нь мэргэ худлаа гэж
Одоо чи итгэв үү.
Элдвийг бодож битгий шанал!

- Тэнгэр бурхан хүсэхээрээ
Хэзээ ч юу ч хийж дөнгөнө.
- Эдип Хатан чиний минь үг болгон
Өр зүрхий минь догдлуулж байна.
- Иокаста Юундаа ингэтэл гансраад байна вэ?
- Эдип Гурван замын уулзвар дээр
Лаи хороогдсон гэв үү чи?
- Иокаста Дам яриа тийм байсан.
Одоо ч тэгж хэлэлцдэг.
- Эдип Тэр газар чинь чухам
Хаа байгаа бол оо?
- Иокаста Давли, Дельф нутгуудаас
Эхээ авсан гурван урт зам
Тэнд нийлдэг юм гэнэ билээ.
Фокида гэдэг газар гэсэн.
- Эдип Тэр явдлаас хойш чухам
Хичнээн жил өнгөрөө бол?
- Иокаста Өөрийг чинь хаан болохоос өмнөхөн
Энэ мэдээг хотынхонд зарласан юм.
- Эдип Ээ, гуниг, гуниг!
Өөрийгөө би алах нь байна.
- Иокаста Яав даа? Юу болов Эдип хаан?
- Эдип Надаас битгий юм шалгаа
Харагдах төрх нь ямар юм бэ Лаи?
Нас ахисан хүн үү, идэр залуу юм уу?
- Иокаста Буурал туг үс нэлээнтэй
Өсгөлүүн нуруулаг хүн сэн дээ!

- Бараг л чамтай төстэй гэвэл
Буруутахгүй ч байх болов уу.
- Эдип Юутай их аймшиг вэ?
Мэдэхгүй, танихгүйн гайгаар
Нүгэлд унасан байх нь уу би?
- Иокаста Хаан минь юу айлдана вэ?
Даруй учраа хэлээч
- Эдип Сохор тэр өвгөн
Далдыг харах чадалтай байжээ?
Дахиад цааш нь ярьж үз.
Учир нь тунгаагдах байгаа...
- Иокаста Аймаар байна даа, гэвч
Мэдсэн дуулснаа ярья
- Эдип Цөөн дагуултай явсан уу?
Эсхүл эзэн хааны ёсоор олон хүнтэй явсан уу?
- Иокаста Тавуулхнаа явсан юмдаг.
Тэдний нэг нь мэдээч байсан.
Сүйх тэргэндээ Лаи ганцаараа
Сууж морилон явсан юмдаг.
- Эдип Чааваас, чааваас! Учрыг оллоо!
Хааныг хороогдсон тухай
Хэн хэл болж ирсэн юм бэ?
- Иокаста Нэг боолын аз болж
Амьд гараад зугтсан юм билээ.
- Эдип Тэр одоо ордонд байна уу?
- Иокаста Үгүй ээ. Боол эндээ ирээд
Лаи хааны ширээнд
Чамайг сууна гэж дуулмагцаа
Төв хотоос холхон сууя
Тэртээ хөдөөд хоньчин больё гэж

Гарь минь атган, хөлд минь мөргөж
Гуйж гувшаад байхаар нь
Дуры нь дагуулаад явуулчихсан юм.
Боол ч гэсэн тэр хүнд
Илүү хишиг хүртээх байсан юм.

Эдип Түргэхэн нааш нь ирүүлж болох уу?

Иокаста Бололгүй яахав, тэгэхдээ
Ямар хэрэг байна аа?

Эдип Гэргий минь би их айж байна
Хэтэрхий их юм ярьчихлаа
Тэр боолтой уулзах хэрэг
Тун их байна надад.

Иокаста Тэр боол ирэг л дээ.
Тэгэхдээ хаан таны юунд зовсныг
Би бас сонсох эрхтэй биш үү?

Эдип Чамдаа би хэлэлгүй яахав.
Өөрт минь их л аймшигтай байна
Өр зүрхний зовлонгоо
Гэргийдээ ярьж хэлэхээс биш
Өөр хэнд нээхэв.
Хайртай миний гэргий
Үг гээлгүй сонсоорой.
Коринфод төрсөн Полиб гэгч эцэг минь билээ.
Дорян нутгаас гаралтай Метропа эх минь билээ.
Нэртэй хүний, зүстэй хүү байлаа.
Гэтэл гайхаш төрмөөр явдал болсон юм.
Тэгэхэд би их уурласан юм.
Манай найран дээр согтсон нэг хүн
Хааны хүү чи биш гээд
Нутаггүй, төрөлгүй, завхуул гэж
Элдвээр намайг доромжилсонд
Биеэ би ашигүй барьж чадсан юм.
Маргааш нь ээж, аавдаа хэлсэн чинь
Хачин их уурлаж байна.
Миний дотор ч онгойж байна.

Гэсэн ч эргэлзээ арилсангүй
Явган яриа ч сэмхэн дэгдлээ.
Тэр даруй Дэльф рүү явлаа.
Эцэг эхдээ ч хэлсэнгүй
Дэльфийн бурхан Аполлон
Даан их нацтай ярьсангүй
Харин эхтэйгээ чи ханилан сууж,
Хавийнхандаа булай болох
Хэдэн хүүхэд төрүүлнэ.
Өөрийнхөө гараар эцгийгээ
Алж хороох болно.
Ёрын муухай аюул зовлонг
Туулах тавилан чамд байна гэж
Элдэв муу юм ёрлож хэллээ.
Учир утгыг нь бодож үзэхэд
Аймшигт ёрын тэр үгс
Биелэхгүй байх ёстой юм,
Тэнгэрийн одод биднээс
Хичнээн хол байдаг вэ,
Тийм алс газарт
Коринфаас би зайлъя гээд
Яв явсаар тэнд очсон юм.
Чиний саяны үгнээс үзэхэд
Эндхийн хаан хороогдсон байж.
Эхнэртээ би үнэнээ хэлъя.
Гурван замын уулзварт
Намайг хүрэлцэн ирэхэд
Сүйх морин тэрэгтэй
Өвгөн зарц хоёр дайралдаад
Морь хөтлогч, өвгөн хоёр
Намайг замаас зайл гэж
Хүч түрээд болдоггүй.
Хөтчийг намайг түлхэх дээр нь
Уурагдаа би цохиод авлаа.
Тэгээд тэрэгтэй зэрэгцээд ирсэн чинь
Өвгөн тэндээс үзүүртэй модоор
Зулай руу минь зэгсэн хатгалаа.
Би хариугаа сайхан авсан.
Хүнд модон таяганд минь өртсөн
Өвгөн тэрэгнээсээ өнхрөөд

Амыгүй шахам газар уналаа.
Би ч цөмий нь хөнөөлөө.
Хэрэв тэр...Лаи хаан...мөн бол...
Ай, надаас илүү хувьгүй амьтан
Энэ хорвоод байх уу?
“Хүний өөрийн хэн ч гэсэн
Ийм нүгэлтэнг хөөх ёстой,
Гэртээ орогнуулж болохгүй” гэсэн чинь
Ийм нүгэлтэн нь би болох нь!
Өөрөө өөртөө хараал авчирлаа!
Хөнөөгдсөн хааны арнун орыг
Цустай гараар би бузарлаж байна.
Адгийн яргачин би биш үү?
Бурхангүй чөтгөр би биш үү?
Эндээс зугтахад болмоор байна...
Хайртай ээж аав, төрсөн путагтаа
Даанч би очиж болохгүй юм.
Төрүүлж хүмүүжүүлсэн эцэг Полибоо
Би хороох тавилантай учраас
Тээж өсгөсөн ээжтэйгээ
Ханьцан суух хувьтай гэдэг
Хүний биш дээрхийн зохиолоор
Ийм зовлон ирнэ байх.
Гарцаагүй болох нь магад.
Дээд тэнгэр сонс!
Та нарын ёр биелэхгүй.
Би ертөнцөөс зайлна
Ийм гай над бүү ирэг!

Найрал дуучид Эзэн минь бид нар ч айчихлаа.
Нүдээрээ үзсэн хүнээс
Үг дуулахаас нааш
Битгий өөрийгөө тарчлаа.

Эдин Найдаж хүлээх юм нэг л байна
Хоньчин өвгөн л ирээсэй.

Иокаста Тэр ирээд яана гэж дээ?

- Эдип Чиний хэлснийг тэр хэлбэл
Би аюулаас аврагдана.
- Иокаста Хэрэгтэй юм би юу хэлэв?
- Эдип Дээрэмчид хааныг хороосон гэж
Хоньчин өвгөн ярьсан гэл үү?
Олон хүн болно шүү дээ.
Ганц хүн дайрсан юм гэвэл
Нүгэл надаас зайлахгүй.
- Иокаста Хаанаас даа, миний хэлснийг
Тэр яг л ярьсан юм.
Би ганцаараа дуулаагүй
Хот даяараа сонссон юм чинь.
Хоньчин өвгөн үгээ буцлаа ч
Надаас гарсан хүү минь
Лаи хааныг ална гэсэн
Аполлон бурхны айлдсан
Үг үнэн гэдгийг
Тэр баталж дийлэхгүй.
Миний хөөрхий хүү минь
Нялхдаа ертөнцөөс хагацсан юм.
Ийм учраас бурхдын айлдсаныг
Би одоо ч итгэхгүй,
Цаашид яасан ч үнэмшихгүй,
- Эдип Чиний хэлж байгаа зөв. Гэхдээ
Хоньчныг даруй авчруулахаар
Одоохон хүн явуулж үз.
- Иокаста Хүн, ингээд явуулъя
Ордондоо хоёулаа оръё л доо
Чиний хэлсэн үг бүхнийг
Биелүүлэхэд би бэлэн байна.
- Бадаг 1
Найрал
дуучид Тэнгэрийн оронд бий болж бүтсэн
Тэтгэмж мэргэн хуулийн дагуу

Үг үйлэнд шударгыг мөрдөхөд
Тавилан ерөөл гуйвахгүй болтугай.
Мөнхөд туяарах хуулийн төрлийн
Эцэг нь гэвэл Олимп мөн.
Харалган тайвспрал тэрнийг
Хэзээ ч унтрааж чадахгүй.
Бүхнийг чадах дээд тэнгэр
Хуучралгүй тэргүүнд оршдог юм.

Эсрэг бадаг 1 Олныг зовоогч мэдэлтэн
Бардам сэтгэлээр төрөөд
Юм бүхэнд ханаж цадаад
Санааны сайныг агуулж
Амьтанд тус болох юмнаас
Хол хөндийрч явчихдаг.
Жаргалын дээдэд ийм хүн хүрмэгц
Торж тогтож чадалгүй
Зовлонгийн далайд унадаг юм.
Хотдоо хэрэгтэй бүхнийг бүтээх
Хичээнгүй сэтгэлий минь дэмжин хайрла, бурхан аа!
Хотол олныг минь туслан нийгүүлс, тэнгэр ээ!

Бадаг 2 Үйл хэрэг, хэлээр ч
Биеэ хүн хэт тоогоод
Хуулийн үнэнээс айхгүй
Хурмас тэнгэрийг бишрэхгүй
Хоорүү сагсуу нь дэндвэл
Аймшигт зэмлэлд унах болно.
Хуурмаг хэргээр хонжоо олж
Бузар үйлээс цааргалаггүй
Ариун нууцыг довтолдог бол
Тэнгэрийн хилэгнэлээс хүн аварсан гэж
Гайхуулах хэрэг байна уу түүнд?
Ай, ийм хүн алдарших юм бол
Бишрэлийн дуулал оргөх хэрэг байна уу?

Эсрэг бадаг 2 Дээд бурхны буулгасан төлөг
Үнэн биш худлаа болбол
Сүсэглэл хүндлэлийг санаандаа агуулж

Ариуныг хадгалсан тэнгэрт залбирахгүй.
Олимп уул, Абайн сүм рүү ч зүглэхгүй
Харин хүчирхэг Зэвс чи үнэхээр
Далдыг мэдэж соёрхдог бол
Таны мөнхийн эрхшээл дор
Санаа муут зэмлэл хүлээнэ.
Аяа, Лаи хааны тухай таамаглал
Хүчингүй болов бололтой.
Аполлон бурхан хүндгүй болж
Мөнхийн сахиусыг бид мартжээ...

Иокаста

Энэ хотын хүндэт эзэд ээ
Хүж зул, шинэхэн цэцэг бариад
Тэнгэрийн сүмд очих минь.
Эдипийн сэтгэл хэт донсолжээ.
Гаслант бодолд автаж
Өнгөрснийг тунгааж ирээдүйг сэтгэх
Ухаан санаа нь алдагдаад
Аймшиг зөгнөж хэлсэн хүний
Үгийг зөвхөн сонсож байна.
Тийм биш гэсэн миний яриа
Тэрэнд тус болохоо өнгөрчээ.
Ингээд би залбирал, гуйлтаа сэтгэлдээ агуулж
Бэлгийн юмсаа гартаа бариад
Ликейн Аполлон танд бараалхъя.
Гай гамшгаас гэтэлгэж хайрла.
Далайн шуурганаас айгаад байгаа
Сэлүүрчин залуурчаа хараад
Сууж яваа хүн бүхэн
Арга нь тасарч, тэвдэлд учирдаг шиг
Бид бүгдээр гайхшаа барлаа.
(мэдээч орж ирнэ)

Мэдээч

Хүний путгийн хүндэт та нар аа
Хаан Эдипийн ордон аль вэ?
Хэлээд өгч болохсон бол уу?
Өөрөө чухам хаа байгааг
Хэлээд өгвөл бүр сайн сан.

- Найрал дуучид Ордон нь энэ байна, хүндэт зочоон!
Хүүхдийнх нь эх хатан ахайтан
Энэхэн гараад айсуу байна.
- Мэдээч Эзэн хаанд хань болох
Гэгээн бүсгүй таныг
Буян заяа дандаа дагаж
Бултаар үүрд жаргаарай.
- Иокаста Сайхан ерөөл хэлсэн танд
Хариу сайныг бэлэгдье.
Гуйлт айлтгах гэв үү?
Ямар нэг мэдээтэй ирэв үү?
- Мэдээч Орд харший чинь гялайлгах
Ижил ханий чинь баярлуулах
Тийм мэдээтэй ирлээ, би
- Иокаста Юу гэсэн үг юм бэ дээ?
Хэн чамайг илгээгээ вэ?
- Мэдээч Коринф хотоос зарагдлаа
Миний хэлэх үг нэгэн бодлын баяр,
Нэгэн бодлын гуниг болно, танд!
- Иокаста Юу хэлэх гээд байна аа?
Хоёрдмол утга нь юу ч билээ?
- Мэдээч Коринф хотынхон бүгдээрээ
Хаан эзнээр Эдипийг
Өргөмжлөхөөр тогтоод байна!
- Иокаста Хаан Полибын эрхшээл яагаа вэ?
- Мэдээч Саяхан нас өөд болсон билээ.
- Иокаста Юу, хэлэв ээ чи?
Полиб эзэн бие бараа юу?
- Мэдээч Миний үг худал болвол
Өөрөө би үхье.

- Иокаста Зарц хүүхэн гүйгээрэй
Эдипийг даруйхан дууд...
Далдыг мэдэгч бурхад аль вэ?
Аавыгаа алах тавилан
Надад бий юм гэнэ лээ гээд
Эдил айж зугтаад энд ирсэн чинь
Полиб эцэг нь өөрөө өөд болж
Тэнгэрийн мэргэ худал болжээ.
(Эдил ирэв)
- Эдип Эрхэмсэг хатан та минь ээ.
Юу болоод намайгаа дуудав?
- Иокаста Энэ хүний айлтгалыг сонсоод
Эрхт тэнгэрийн аймшигт толөг
Үнэн, эсэхий нь тунгааж хайрла!
- Эдип Юун хүн юм бэ энэ?
Надад юу айлтгах гээв?
- Иокаста Холоос ирсэн хүн юм.
Тансаг таны эцэг Полиб
Насан эцэс болсон гэнэ.
- Эдип Айлчин хүн чи, юу гэнээ?
Өөрөө хэлээд өгөөч.
- Мэдээч Тэнгэрийн буурал аав чинь өөд болоод
Биднээс салж одлоо.
Урьтаж би айлтгах ёстой бол
Миний мэдээ энэ байна.
- Эдип Хүний гарт өртөв үү?
Өвчин дайрч гэнэдэв үү?
- Мэдээч Насан туйл болсон хүнд
Хутаг орших юухан байхав?
- Эдил Эмгэг өвчнөөс болоо шив дээ?

- Мэдээч Өнө өндөр насалсан биш үү?
- Эдип Аяа, хөөрхий,
Төрсөн эцгээ хороох тавилантай гэж
Мэргэдийн хэлснийг итгэж
Шувуун нисэлтийг ажин байхын
Хэрэг юусан билээ?
Мэс гартаа бариагүй байхад
Аав минь өөрөө нас бараад
Газарт хэвтнэм биш үү?!
Хүү намайгаа мөрөөдөн санасан нь
Өвчин болж шаналгаад
Аминд нь хүрсэн юм биш байгаа?
Хэрэв тэгсэн юм бол би
Буруут гэмтэн болох биш үү?
Гэсэн ч энэ удаа Полиб аав минь
Дээдсийн төлөг худал болохыг
Олонд нотолж өглөө байна.
Үнэндээ төлөг гэдэг бол
Хоосон үгнээс цаашгүй юм.
- Иокаста Энэний тухай би танд
Бишгүй л үглэдэг байсан даа.
- Эдип Чи минь хэлдэг л байсан
Гэсэн ч би айсаар байна.
- Иокаста Одоо та минь айх юм үгүй
- Эдип Ээжтэй холбогдоно гэсэн үг
Бас л дотор хадаастай,
- Иокаста Хүн төрөлхтөн бидэнд
Айх юм юу байгаа юм.
Мэргэ төлөг хамаарахгүй,
Харин санамсаргүй тохиолууд
Зовлонд унагаж магадгүй.
Гэхдээ эзэн хичээж явбал
Заяа хичээнэ гэдэг.
Амьдарч чадах чадлаараа л

Тавтай амьдрах хэрэгтэй...
Ээжтэйгээ ханилна гэж
Төлөг бууснаас битгий зов
Дуг нойрны муухай зүүд
Сэрэхэд худал байдаг биш үү?!

- Эдип Чиний хэлдэг үндэстэй...
 Гэсэн ч ээж минь амьд мэнд
 Тэрнийгээ амьд байгаа болохоор
 Чи хичнээн ятгасан ч
 Муу юм санаанаас гарахгүй юм.
- Иокаста Төлгөөр бол эцгээ та хороох байсан
 Тэр худал боллоо.
 Одоо ядаж тайвширч болно биз.
- Эдип Ай тэр бүхэн тийм байвч...
 Амьд байгаа...тэр минь
 Намайг айлгаад байна шүү.
- Мэдээч Хэнээс ингэтлээ айнам билээ та?
- Эдип Полиб хааны бэлбэсэн гэргий,
 Хатан Меропыг хэлж байна, өвгөөн.
- Мэдээч Тэрнээс юунд их айнам билээ?
- Эдип Тэнгэрийн төлгөнд муу юм буусан юм.
- Мэдээч Чухам юу гэснийг
 Боол би дуулж болохсон бол уу?
- Эдип Болно. Би хэлье.
 Эцгийнхээ амийг хороож
 Эхтэйгээ ханилан сууна гэж
 Дээр үед нэг мэрэгч
 Надад төлөг буулгасан билээ.
 Тэгээд би нутгаасаа холдож
 Энд суусан юм.

- Гэхдээ төрсөн нутгийг гүйцэх орон
Дэлхийд хаа байх билээ.
- Мэдээч Айгаад энэ рүү өөрийгөө
Цөлж явуулсан хэрэг үү?
- Эдип Аавыгаа хороохоос эмээсэн билээ.
- Мэдээч Тэгвэл, эзэнтэн, таныг би
Тээнэгэлзэл зовлонгоос салгана.
Юуны тулд олондоо
Сайн үгт мэдээч гэж
Алдаршаад байгаа билээ.
- Эдип Шан харамж хүртээнэ би
- Мэдээч Төрсөн Коринф нутагт чинь буцаах хэргээр
Би тэндээс зарагдсан.
Одоо шангаа хүртье.
- Эдип Төрсөн гэртээ хэзээ ч очихгүй.
- Мэдээч Гэрээс холдсон шалтгаан чинь
Хэрэв энэ л юм бол...
- Эдип Юув өвгөөн? Түргэн хэл
- Мэдээч Хүү минь чи тусгүй байна.
- Эдип Тэнгэрийн заасан биелбэл яана...
- Мэдээч Эцэг эхээсээ хол байж
Бузраас зугтсан хэрэг үү?
- Эдип Тийм өвгөн, энээс л айна.
- Мэдээч Айх эмээх ямар ч хэрэггүй.
- Эдип Тэд намайг төрүүлсэн?

- Мэдээч Хаан Полиб танд хамаагүй
- Эдип Төрүүлсэн эцэг минь биш гэж үү?
- Мэдээч Би таныг төрүүлсэн гэвэл
Та надад итгэхгүйн адил
Тэр таны эцэг биш.
- Эдип Та миний юу ч биш ээ.
Тэр бол миний аав шүү.
- Мэдээч Би ч танд ер хамаагүй.
Тэр ч таны юу ч биш.
- Эдип Тэгвэл намайг хүүгээ гэж
Юунд энхрийлж байсан юм бэ?
- Мэдээч Надаас чамайг бэлгэнд авсан юм.
- Эдип Хүний үрийг тэр хүн
Тийм их хайрлаж чадах уу?
- Мэдээч Үргүйн зовлонгоор зүдэрч байсан юм.
- Эдип Намайг та олсон юм уу?
Хүнээс худалдаж авсан юм уу?
- Мэдээч Их хавцлын ой дундаас олсон юм.
- Эдип Тэр рүү юу гэж тэнэж явсан юм бэ?
- Мэдээч Ууланд хонь хариулдаг байлаа.
- Эдип Хөлсний боол, хоньчин байсан юм шив дээ?
- Мэдээч Чамайг аварсан юм, хүү минь.
- Эдип Би тэгэхэд ямар байсан юм бэ?

- Мэдээч Чиний шилбэ чинь цоолтуур нүхтэй
Хөдөлж чадахгүй байлаа.
- Эдип Өнгөрсөн зовлонг тоочоод яахав?
- Мэдээч Шөвгөөр хатгуулсан хөлий чинь
Би эмнэж эдгээлээ.
- Эдип Ээ бурхан минь буруут хүн хэн бэ
Аав уу? ээж үү?
- Мэдээч Чамайг надад өгсөн хүн
Надаас илүү мэдэхсэн биз.
- Эдип Өөрөө та олоогүй,
Дамаа хүнээс авсан юм уу?
- Мэдээч Бас нэг хоньчин
Надад өгсөн юм.
- Эдип Ямар хүн өгсний нь
Хэлж өгөөч надад
- Мэдээч Лаи хааны зарц гэсэн байх
- Эдип Фив хотын хааны юу?
- Мэдээч Тийм ээ, хааны хоньчин гэж байсан.
- Эдип Тэр хүн амьд бол уу?
Нүүр учирч ярих юмсан...
- Мэдээч Эндэх нутгийн улсууд та нар
Надаас илүү мэдэх биз.
- Эдип Энэ элчийн дурссан хоньчинг
Та нар мэдэх үү, хөгшид өө?
Хээр хөдөө уулзсан байх,
Энд тэнд дайралдав уу?
Учир олдох хугацаа болж.

- Найрал дуучид Таны уулзъя гэсэн өвгөн
Мөн бол уу гэж таамаглана.
Иокаста л сайн мэднэ.
- Эдип Элчийн дурссан хоньчин
Ирэх хүн чинь биш биз?
- Иокаста Юуны хамаа байнав? Болиоч!
Хэрэггүй үгийг...сонсоод яах юм бэ?
- Эдип Ийм үзүүр гараад байхад
Хэнээс төрснөө заавал мэдье.
- Иокаста Аминдаа хайртай, намайг боддог бол
Асууж сураглаад хэрэггүй биз...
Энэлсэн сэтгэлий минь амраа!
- Эдип Зоригоо хатуу барьж үз.
Би боолоос төрсөн байлаа ч
Чиний дээд төрөл арилахгүй.
- Иокаста Миний үгийг сонсооч.
Тэрнийг дуудах хэрэггүй!
- Эдип Намайг ятгаад нэмэргүй
Учрыг би олно.
- Иокаста Чамд л сайныг хүссэн юм
Миний хэлснийг бод.
- Эдип Чиний яриа яришиг болж байна.
- Иокаста Азгүй амьтан! Хэний хүү болохоо
Чи мэдээд хэрэггүй!
- Эдип Явцгаа. Хоньчинг одоо аваад ир.
Баян ураг төрлөөрөө
Чи ганцаараа гайхуул.

Иокаста Аяа, муухай заяатай амьтан.
Энэ үгийг би чамд хэлээд
Үүрд дахиад дуугарахгүй.
(явна)

Найрал дуучид Хүлцэшгүй зовлонд дарагдаад
Хайчив, гэргий чинь Эдип ээ?
Үг цөөнтэй хүн
Нэг дуугарвал хэцүү биш үү?
Эдип Яасан ч яахав? Өнгөрч!
Доодын доод гаралтай ч гэсэн
Угсаа төрлөө мэдэх хэрэгтэй.
Бүсгүй хүний сэтгэл
Гайхуулж бардах дуртай хойно
Гарал доодтой надтай ханьцсандаа
Ичиж зовох юм байгаа биз.
Сайн мууг билэгдэж байдаг
Үйлийн үрд л захирагдана.
Муу тавиланд дайрагдлаа ч
Ичих юм надад алга.
Миний угсаа тийм л бол өөрчилж би чадахгүй.
Гарал үүслээ би
Заавал мэдэх ёстой.

Найрал дуучид Миний мэргэн сүнс
Далдыг мэдэх билигтэй бол
Харах асрагч эцэг нь болсон
Хаан Эдипийн төрсөн нутаг
Киферон чиний алдрыг бид
Тэргэл сартай маргааш
Магтан дуурсахыг сонсох болно.
Энэ нутгийн олонд
Чиний өөдрөг үйлс
Эртнээс хэрэгтэй байсан билээ.
Тойрон бүжгээ ч маргааш хийнэ.
Биднийг нигүүлс Феб минь
Чиний хайрыг сөгдөн дууднам билээ.

Эсрэг бадаг Урт насалдаг олон охидын
Хэн нь энэнийг төрүүлсэн юм бол

- Атар сайхан хээр нутагт
 Байдаг хайраа шингээсэн
 Уулын зочин ноён эцэг
 Үгүй бол Локсий эзэнтэн
 Нимфд халдаа юм бол уу?
 Киллен нутгийн эзэн хаан
 Чамайг төрүүлсэн эцэг үү?
 Дээд бурхан Нимфудтай
 Наадан байдаг газраас
 Геликон уулын оройг
 Эзлэнхэн төрсөн Вакх
 Нимфээс чамайг эх барьж аваа юу?
- Эдип
 Хоньчинг би зүс танихгүй ч
 Бидний хүлээсэн хүн маань
 Тэр, ирэв бололтой, өвгөд өө!
 Насаар өндөр болсон юм байна.
 Мэдээчтэй чацуу бол уу?
 Дагалдагчды нь би танилаа.
 Миний боолууд бололтой...
 Хоньчныг олон харснаараа
 Чи л тодруулж хэлнэ үү?
- Найрал дуучид Би энэнийг сайн мэднэ
 Лаи хаанд үнэнч хоньчин нь байсан юм.
(Хоньчин ирэв)
- Эдип Коринфийн зочин танаас лавлая.
 Энэ хүнийг хэлсэн үү та?
- Мэдээч Тийм ээ, мөн байна, аргагүй
- Эдип Өвгөн гуай минь үнэнийг хэл
 Нүд рүү минь хараад ярь,
 Лаи хааны боол уу чи?
- Хоньчин Тийм ээ, тэгэхдээ намайг
 Худалдаж аваагүй юм.
 Гэртээ төрөөд, дэргэд нь өссөн юм.
- Эдип Юу хийж, амь зууж байв?

- Хоньчин Насны ихэнхийг мал дээр өнгөрөөсон.
- Эдип Голдуу хаагуур нутаглаж байв?
- Хоньчин Киферонд голдуу, тойронд нь ч байсан.
- Эдип Өөрий минь та сайн таних уу?
Нүүр учирч явсан уу?
- Хоньчин Юу хийдэг хүнсэн бол?
Хэний тухай айлднам бэ та?
- Эдип Миний тухай намайг хар
Нүүр үзсэн байна уу?
- Хоньчин Яаж мэдэх вэ? Магадгүй биз.
Гэнэтхэн санахгүй л байна даа.
- Мэдээч Энэ ч аргагүй эзэнтэн.
Гэвч мартсанаа тодорхой санахаар юм
Би яриад хөндөөд өгье.
Кифероны нутгаар тэнүүчилж холхисноо
Энэ хүн яасан ч мартаагүй.
Хаврын эхэн сараас
Сэрүү унатал бид хоёр
Гурван жил дараалан
Мал хариулдаг байсан юм.
Энэ маань хоёр суурь малтай
Би ганц суурь хариулж байлаа
Өвөл болохоор би
Өвөлжөөндөө аваачдаг.
Энэ маань малаа туугаад
Лай хааны байранд хүргэдэг
Миний хэлж байгаа үнэн биз?
- Хоньчин Он жил олон улирч...
Тэглээ ч үнэн байнаа
- Мэдээч Төрсөн үр шигээ хайрлаж яв,
Сайхан өсгөж гараасаа хөтөл гэж
Та надад нэг хүү өгсөн өө?

- Хоньчин Тэгээд яасан гэж?
Энэнийг яриад яах нь вэ?
- Мэдээч Тэр хүү чинь өвгөн гуай,
Энэ хүн байсан юм байна шүү
- Хоньчин Хараал чамд хүрэг
Дуугүй болоод өгөөч.
- Эдип Энэнийг өвгөн чи битгий загна
Харин чамайг зэмлэмээр байна.
- Хоньчин Хаан эзэн өршөөж хайрла
Буруу хэрэг хийв үү би?
- Эдип Хүүхдийн тухай ярихгүй нь үү?
- Хоньчин Энэ хүн тэрнийг ердөө ч мэдэхгүй.
Дэмий юм ярих гээд байх шиг.
- Эдип Мэдэхээ ярьж өгөхгүй бол
Ташуур хэрэглэж болно шүү.
- Хоньчин Танд мөргөө. Битгий зодоорой.
- Эдип Гары нь ард нь хүлээд орхи.
- Хоньчин Аз надаас харьсан байна уу?
Та юу мэдэх гээд байна вэ?
- Эдип Хүүхэд энэд өгсөн үнэн үү?
- Хоньчин Өгсөн...тэгэхэд үхэх минь яав даа...
- Эдип Үнэнийг хэлэхгүй бол үхнэ дээ.
- Хоньчин Хэлбэл харин түргэн үхнэ.

- Эдип Цааргалж гарах санаа
Танд тун их байна аа?
- Хоньчин Өөрийн биш...Хүнээс авсан юм.
- Эдип Хаанах айлын, хэнээс тэр вэ?
- Хоньчин Цааш нь битгий асуу.
Тэнгэрийг барьж би гуйя.
- Эдип Олон дахин асуухгүй шүү
Амий чинь дор нь хорооно.
- Хоньчин Лаи хааны гэрийн нэг хүнээс
Би тэр хүүхдийг авсан билээ.
- Эдип Хааны төрөл хүн юм уу?
Боол нь байсан хэрэг үү?
- Хоньчин Аяа, яанаа! Аймшигт явдлыг
Бултыг нь ярьж дээ...
- Эдип Би дуулж сонсох болж...
Ямар ч байсан би мэдэх ёстой.
- Хоньчин Лаи хааны хүүхэд нь юмсан.
Хатнаасаа асуу даа, та
- Эдип Нялх үрээ тэр, танд өгсөн хэрэг үү?
- Хоньчин Ёсоор тийм ээ, хаан аа!
- Эдип Яах гэж тэр вэ?
- Хоньчин Хороо гэсэн юм.
- Эдип Эх нь үрээ хороо гэсэн юм гэж үү?
- Хоньчин Дээрхийн зарлигаас эмээсэн юм гэдэг.

- Эдип Ямар зарлигаас тэр вэ?
- Хоньчин Эцгийнхээ аминд хүрэх хүү гэж
Нэг мэргэн айлдсан юм гэдэг.
- Эдип Тэгэхэд чи яах гэж өөр хүнд
Дамжуулж өгсөн юм бэ?
- Хоньчин Өрөвдөж хайрлаад болоогүй юм
Холын нутагтаа аваачаад
Төөрүүлнэ биз гэж санасан юм.
Гэтэл аюулт зовлонд учруулах гэж
Хүүхдийг аварсан байжээ.
Тэр хүү чи мөн бол
Гамшиг эдлэх хүн шүү чи!
- Эдип Аяа, хөөрхий нэрвэгджээ би!
Одоо л учир тодрох нь.
Гэгээн ертөнц чамайг
Эцсийн удаа харнам би!
Хараал хүртэхээр төрөөд
Хар гайг эдэлжээ.
Төрснийхөө цусыг асгаруулж
Ялт хэрэг хийсэн байна!
(орд руу гүйн оров)
- Бадаг 1 Хүмүүс, хүмүүс, ертөнцөд амьдрагсад!
Амь зууна гэдэг зэрэглээ биш үү
Аз жаргалтай хэн золгосон бэ?
Заяа надад олдлоо гэж
Бодож амжив уу, үгүй юу
Алга болдог юм биш үү, тэр?
Эдип хааны хувь тавилан
Надад их юм сургалаа.
“Хорвоод азтай хүн” гэж
Ер нь байхгүй юм биш үү?
- Эсрэг бадаг Чиглэсэн зориг зүрхээрээ
Жаргалыг энэ хүн барьсан билээ.
Ай, Зэвс бурхан сонсон айлд.
Ёр муутай дуунууд дуулагч

Бузар шулмыг энэ устгаад
Тэнүүн энэ нутгийн
Аврагч нь болж ирсэн билээ.
Тэр цагаас хойш Эдин та
Хаан их нэрэнд хүрсэн биш үү.
Аугаа Фив хотын
Иргэн хүн бүр таныгаа
Дээд хүн хүндэтгэлээр
Хүрээлж байсан биш үү.

Бадаг 2

Үйлийн хүндийг үүрч аваад
Зовлон гаслангийн урьхинд баригдан
Ингэж тамлагдах хүн бий бол уу?
Энэнээс азгүй хүн гэж байх уу?
Алдрын дээлд хүрсэн Эдип
Бүр өнгөрч гүйцжээ.
Ижил ханьтай боллоо гээд
Дэр нийлүүлээ гэсэн чинь
Юу болоо юм бэ мэдэхгүй
Хүү нь болов уу, эр нөхөр нь уу.
Аз муу эр гэж
Энэнийг хэлэх биш үү?
Эцгийнхээ оронд нөхөр нь болж
Хичнээн ч болов доо энэ.
Хэн үүнийг мэдсэн юм бэ?

Эсрэг бадаг

Бүхнийг нээсэн цаг хугацаа ирээд
Өөрийн нь хүү байж хүүхдийн нь эцэг болсон
Бузар тавилангий нь буруутгалаа.
Гаслантайяа. Лан хааны золгүй хүү чи байна.
Нүдэндээ чамайг үзээгүй ч болоосой.
Насан эцэслэсэн хүний төлөө
Гутарч байгаа юм шиг л байна би.
Сайхан жаргалыг бидэнд авчирснаа
Саар харанхуйгаар дахин бүрхлээ.
(Гэрийн хүн орж ирнэ)

Гэрийн хүн

Нутаг нэгтэй хүндэт иргэд ээ!
Юу сонсож, үзнэ байгаа гэж боднов та нар
Хаантны гэр бүлд үнэнч хүн бүр

Ямар их зовлонд учирлаа гэж санаа аа!
Истр, Фасис хоёр ч атугай
Ладакийнхны оронг ариутгаж
Тунгалаг болгож чадахгүй.
Хичнээн муу, муухай юм
Энд нуугдаж байна гэж бодно оо.

Өөрөө хийсэн лайг өөрөө эдлэх гэдэг
Юу юунаас илүү гашуу.

Найрал дуучид Мэдэгдээд байгаа энэнээс хүнд
Гамшинг, гачаал гэж байх уу!
Бас юу болоов?
Бидэнд хэлээч!

Гэрийн хүн Ярих сонсоход амархаан
Тэнгэрлэг Иокаста байхгүй болсон.

Найрал дуучид Азгүй хэрэг вэ энэ чинь?
Учир нь юунд юм болоо.

Гэрийн хүн Аяа, учир өөрт нь байсан юм байх
Миний нүдээр харсан бүхнийг
Чи үзээгүй болохоор
Над шиг гашуудалд унахгүй биз.
Хязгааргүй гасланд дарагдаж
Нойрсох танхимдаа оронгуутаа
Орон дээрээ савж унангуут
Толгойтой үсээ зулгаалаа.
Орох санаатай байтал минь
Хаалгаа тас хийтэл хаагаад
Насан өөд болсон хаан Лаиг
Хашгиран дуудаж үглэхдээ
Ууган хүү нь эцгийгээ хороож
Тэр хүүтэйгээ өөрөө ханилаад
Хүүхэд гаргасан нүгэл ланчгаа
Тоочин дурсаж байна билээ.
Нөхөр, хүү хоёртойгоо
Нойрссон орон дээрээ хайлж
Хүүгээсээ хүүхэд төрүүлснээ

Дахин дахин дурссаар
Насан хутаг эцэслэсэн.
Гэтэл гэнэт Эдип хаан бас
Орилон чарласаар ирсэнд
Хатныг ажиглахаа мартаж
Хааныг харсан чинь хальтрам,
Зүрх дэлбэчим байлаа даа.
Сэлэм, мэс авчир л гэнэ.
“Миний гэргий яасан бэ?
Гэргий биш ээ, ээж минь!
Хүүтэйгээ ханилаад үр төрүүлсэн
Ээж минь хаа байна” гэлээ.
Дээд тэнгэрийн далдын их хүч
Сүнсий нь хөтлөх гээд байсан.
Жирийн боол бид
Яаж ч чадахгүй нь билээ.
Тэгээд гэнэт архирич хүрхрэн
Хүн харж хөөх болоод
Хаалганы зүг үсрэн очсоноо
Цоож цуургы нь хэмх татаад
Нойрсох өрөөндөө орчихлоо.
Гэтэл хатан боомлоод өөдөлчихсэн
Олсонд дүүжийгнэн байх харагдлаа.
Хаан тэрнийг гэнэт хараад
Гаслан зовж орилсоор
Олсы нь тас огтолсон чинь
Зовлонг эмэгтэй газар ойчлоо.
Дараа нь...хэлэхэд бүр ч аюултай.
Хатан өмсгөлийнх нь нөмрөгийг аваад
Алтан зүүлтний нь том зүүгээр
Нүдээ хатгаж эхэллээ.
“Хийсэн хэргийн муу муухайг,
Төлөөнөөс нь эдлэх зовлонг
Энэ нүд үзэх ёсгүй,
Энхрий хайртай хүнийхээ
Зүс царайг таниагүй
Энэ нүд үлдэх ёсгүй” гээд
Нүдээ ганц нэг хатгаагүй,
Хичнээн төчнөөн хатгахад нь
Цус дуслаар гараагүй

Хар хүрэн цусан гол
Газраар нэг урсах шиг болсон
Өнгөрсөн цагийг нь одоо санахад
Атаархам жаргалтай байсан биш үү?
Хичнээн дөлгөөн, ухаан төгс,
Шударга ч чадамгай ч
Заяа бүрэн хүмүүс байлаа.
Үхэл зовлон, бузар гутамшиг
Бүгд эдэн дээр бөөгнөрчээ.

Найрал дуучид Одоо ер яагаа бол?
Ухаан орсон уу, үгүй юү?

Гэрийн хүн Төрсөн эцгийгээ хороосон,
Энхрий эхийгээ...хэлэхийг түдгэлзье.
Орон гэртээ хараал авчрахгүйн тулд
Одоохон өөрөө би эндээс зайлна,
Хаалгаа нээ, бузар намайг залхаа гэж
Хашгиран, чарлан шаналж байна.
Тэнхээ чадал нь барагдсан даа
Тэтгэж авч явах хүн хэрэгтэй биз
Энэний зовлонг зүйрлэж хэлэхэд
Тэнгэсийн уснаас ч гүн!
Шовх сарьдгаас ч өндөр!
Одоо та бүгд толилно доо...
Хаалганы төмөр цүүг тайлж байна...
Харахад нүд хальгармаар
Дайсан ч тэрнийг өрөвдмөөр болсоон.

Найрал дуучид Аяа, хүн болж төрөөд
Ийм гасланг үзэх хүнийг
Энэнээс илүү шаналлыг
Би огт харсангүй ээ.
Аз муут амьтан чи байж!
Ухаанд багтангүй юун их зовлон бэ?
Чиний хувьгүй заяаг гишгэхээр
Ямар муу ёрын чөтгөр
Үсэрч гэнэт хаанаас ирэв?
Чамайг харахад нүд дальдарна.

Гэтэл асууж мэдмээр их юм байна!
Яана даа, яана, юутай аймшигтай вэ?

Эдип Гаслантай хар тавилан минь!
Юу болох нь энэ вэ?
Зовлон шаналалд хөтлөгдсөөр
Хаашаа би явах юм бэ?
Гутамшигт дуу минь хаа хүрэх юм бэ?
Заяа тавилан гэдэг чинь
Ийм байдаг уу, та минь ээ?
Юунд намайг хүргэх нь вэ?

Найрал дуучид Хүн бүхний жигшлийг
Өөрийн эрхгүй төрүүлэх
Үйлийг та хийжээ.

Бадаг 1
Эдип Гашуудал харанхуйн үүлэн дунд
Яахаа ч мэдэхгүй явнам би!
Дийлдэшгүй шуурган дунд хөвнөм би
Юутай аймшиг
Юутай гутамшиг
Хүйтэн мэс зүрхэнд хатгаастай
Мартагдашгүй гаслан ухаанд шингээстэй

Найрал дуучид Давхар муу ёрд дарагдсан хүн
Хэдэн давхар зовлонгийн тухай
Хашгирч гансрах нь аргагүй...

Эсрэг бадаг 1
Эдип Өнгөрч! Найз минь!
Үнэнч зарц чи л надад үлдэж
Сохор намайг энэрэн үзлээ.
Өнгөрч! Өнгөрч!
Мөнхийн харанхуйд орсон ч би
Чамайгаа илхэн харж байна.
Дуугий чинь тодхон ялгаж байна.

Найрал дуучид Аймшигт хэрэг үйлдсэн чи
Мэлмийгээ яах гэж хөндөөв?
Далдын сахиус тэг гэж айлдав уу?

Бадаг 2
Эдин

Аполлоны зарлиг тэр
Аполлоны шийдвэр нь энэ
Миний зовлонг дүгнэж өглөө.
Миний нүдэнд гар хүрсэн,
Хэн ч байхгүй, та минь!
Би өөрөө ингэсэн юм.
Гуниг! Гуниг!...
Дэлхий дээр харах сайхан зүйл
Надад байхгүй болсноос хойш
Нүдээр ч би яах билээ.

Найрал дуучид Өөрийн чинь зөгнөл-ёсоор болжээ.

Эдин

Юуг би харах юм билээ?
Хэнтэй уулзаж баярлуулах билээ?
Хэнийг бишрэн сонсох юм билээ?
Хорвоог бузарласан намайг
Даруйхан эндээс зайлуул!
Хараалын муу надад хүргэ!
Мөнх тэнгэрийн аянганд би
Дээдийн дээдээр нэрвэгдэх ёстой!

Найрал дуучид Хувь заяа, сэтгэл чинь ч зовууртай,
Хорвоод тэнцэх гунигтан алга
Яах гэж чамтай бид тохиолдов!
Юу гэж чамайг бид танив?

Эдин

Нялхад минь холийг минь хүлээд
Хая гэхэд нь аварсан хүн
Амьдын жаргалыг эдлүүлэх биш
Гаслангийн далайд хаях гэж
Амийг минь үлдээсэн байх нь!
Тэр цагтаа л өнгөрсөн бол
Миний төрлүүд, би ч гэсэн
Энэ их зүдүүрийг эдлэхгүйсэн!

Найрал дуучид Тэгсэн бол нээрэн дээр байж
Энэ ч чиний бодсон зөв.

Эдип Наашаа ирж эцгийгээ хороогоод
Төрсөн ээжтэйгээ ханилахгүйсэн.
Эх үрийн барилдлагааг
Эвдэн бузарласан гутамшигт ялтан
Би болохгүй байсан билээ.
Ай хөөрхий, эвий хөөрхий!
Зовлонгийн дээд зовлон гэж
Онцгой юм байдагсан бол
Тэр бүхнийг Эдип амсжээ...

Найрал дуучид Өөрийгөө зэмлэн, өөрийгөө хорлосон
Чиний үйлдлийг магтах уу, болих уу?
Би сайн мэдэхгүй байна.
Харин ингэж сохорсонд орвол
Хүн болж төрөөгүй бол дээр байж.

Эдип Өөрийгөө өөрөө яллалаа гэж
Битгий намайг зэмлэ
Битгий намайг сурга
Арван тамын ёроолд оччихоод
Хараатайгаа байвал та минь
Хайртай эцгийнхээ нүүрийг
Энхрий ээжийн барааг
Яаж би харах юм бэ?
Тэдний өмнө хийсэн
Миний нүгэл хэмжээлшгүй!
Эхтэйгээ сууж төрүүлсэн
Хүүхдээ харах амархан гэж үү?
Тэднийг харах зориг хүрнэ гэж үү?
Ариун бодисадын баримлуудтай
Бат орших энэ хотдоо
Тэргүүн иргэн нь байгаад
Ийм хэргийг хийснээс хойш
Яаж энэнийгээ харах байв?
Нутгаа зовлонд учруулах, гай гамшгийг авчирсан
Гэмтэн, буруутан хэн ч байлаа
Гэртээ битгий ойртуул

Даруй хөөж явуул гэж
Би эс зарлиг болгол уу?
Тэгээд өөрөө гай тарьчихаад
Олныхоо нүүрийг яаж харах байв.
Тэгж яасан ч болохгүй.
Хэрэв болдогсон бол би
Чихээ ч бас хатгаж цоолоод
Сохор дүлий болчихоод
Тамаа эдэлж явахсан
Даанч чихээ хатгавал
Тэр дороо үхээд
Тарчлах зовлонг эдлэхгүй болно.
Зүдгүүрлэлгүй амь зуух гэдэг
Хичнээн амттай хувь бэ?
Ай Киферон аа!
Яах гэж намайг өргөмжлөн авав?
Авлаа ч гэсэн дор нь алсан бол
Хэнээс ч төрсөн, юу хийснээ ч
Ухааралгүй өнгөрсөн бол
Цээд жаргал байх байжээ.
Полиб, Коринф төрсөн орон гэр минь!
Гаднаа би хичнээн өнгөтэй
Хичнээн нигүүлсэнгүй байлаа!
Тэгтэл дотроо хичнээн буртаг
Хичнээн бузрыг агуулж байв даа.
Гарах жимгүй уулын хавцал,
Гурван замын уулзвар дээр
Халуун цусыг минь тэнд уусан,
Өөрийн гараар би түүнийг асгаруулсан биш үү?
Бас цааш нь юу хийв ээ би?
Хэлье гэтэл хэл хөшгчихөөд
Дотор сэтгэл хүйт дааж байна.
Надаас бузар юм хийсэн хүн.
Хэзээ ч хаана ч үзэгдээгүй...
Бузар бүхнийг тоочих
Юунд хэрэгтэй билээ...
Бурхдыг барьж гуйя даа
Холын хол далдлаач намайг
Үгүй бол та нар алаач,
Үгүй бол хүний нүднээс зайлуулж

Тэнгисийн усанд хаяач.
Тэнд ч атугай би чинь
Загас тэжээж буян үйлдье.
Ойртооч, та нар минь, ирээч
Хувьгүй наддаа гар хүрээч
Миший энэхэн өвчин бол
Хүнд халдаж чадахгүй

Найрал дуучид За тэр, Креонт цагаа олж,
Наашаа айсуй явна.
Хотоо харгалзахаар ганцаараа
Энд үлдээ дээ аргагүй,

Эдип Аяа, юутай хэцүү юм билээ.
Юү гэж ярих билээ.
Өөрөө тэрнийг хар муу санаж хөөсөн юмсан,
Одоо юу гэж хэлэх вэ?
Тэр ч надад юу гэж итгэх вэ?

Креонт Чамайг би шоолох гээгүй,
Урд намайг гомдоосны
Өшөөг чамаас авч
Бахаа хангах гээгүй,
Гэхдээ хүнээс бид нар ичихгүй юм гэхэд
Амьдыг баясгагч нарыг бид
Хүндлэх дээдлэх ёстой биз ээ?
Энэнийг газар булья ч гэсэн
Газар ангайж өгөхгүй,
Хур бороо, тэнгэрийн гэгээ
Аль нь ч энэнийг авахгүй,
Эдипийг даруйхан гэрт нь оруул.
Ойр төрлийнхөө зовлонг
Хамаатай хүмүүс нь л сонсож мэдэх ёстой.

Эдип Бузар намайг ийнхүү гийгүүлж
Айсан сэтгэлий минь амраав хойно...
Сүүлийн удаа нэг юм гуйя.

Креонт Юу гуйж шалаад байнав, та!

- Эдип Хүний энхрий дууг
Би сонсох ёсгүй.
Тийм муу зүг рүү л намайгаа
Түргэхэн тонилгоод өгөөч дээ.
- Креонт Би ч аргагүй тэгмээр байна.
Тэгтэл бас далдын тэнгэрээс
Яахыг асуувал зүгээр бол уу?
- Эдип Над шиг булай амьтныг
Цаазал хороо гэж бурхан
Зарлиг буулгах нь гарцаагүй.
- Креонт Тийм зарлиг буусан боловч
Тээнэгэлзэх хэцүү цагт
Асууж лавлах нь хэрэгтэй.
- Эдип Үхэлгүй мөнхийн эздээс
Чивэлт намайг асууж яах нь вэ?
- Креонт Одоо ер нь чи
Бурханд сүсэгтэй болсон биз?
- Эдип Би чамд нэг юм хэлж
Гуйж мөргөн сөгдөө.
Ордонд осолдсон... тэрнийг
Өөрөө мэдээд оршуулаарай.
Садангийн хувиар ч
Чамд бас хамаарна.
Намайг үхтэл төрөлх энэ хотод минь
Чимээгүй амьдрахыг ч зөвшөөрөхгүй.
Ясаа энд тавиарай гэж
Киферон уулыг эцэг, эх заасан юм болохоор
Тэр рүү намайг илгээж аль.
Тэндээ би насан эцэс болж
Тэднийхээ санаснаар болгоё.
Тэгэхдээ өвчин хүртэл намайг тоохгүй,
Үхэл ч намайг мөдхөн
Аваад явчихгүй даг аа.
Яая гэхэв? Аймшигт олон

Гачаал гамшиг эдлүүлж
Гай тамлалд шумбуулах гэж
Намайг тэр цагт аварсан байж.
Надад ноогдсон хувь ерөөл
Гурим ёсоороо л яваг.
Бүстэй хэдэн хүүхдийн минь төлөө
Санаа зовсны хэрэггүй чи,
Тэд чинь өсөж торниод
Дутаад байх юм ч үгүй болсон.
Надаас салдаггүй охид минь л
Миний гар харж сурчихсан юм.
Одоо тэд нар хэцүүднэ.
Тэднийг минь чи харж
Хандаж дэмжиж байгаарай...
Одоо тэднийгээ нэг нэг тэврээд
Гунигаа дэвтгэл уйлахсан.
Ай хаан аа, тэгж болохсон бол уу?...
Ай ивээгч ээ, боломжийг нь хангаж хайрла.
Тэднийгээ тэмтэрч тэврээд
Ариун үнэрий нь авахад
Нүдээр харснаас өөрцгүй болно.
Би муу амьтан юу үглээд байна аа?
Тэнгэр минь. Чих минь сонор биш үү?...
Энэ байна, хүрээд ирлээ, хонгорууд...
Хэн аваад ирэв ээ.

Креонт

Уулзуулья гэж би бодлоо.
Чиний сэтгэл эднийгээ
Хичнээн мөрөөдсөнийг мэдсэн юм.

Эдип

Ай, тэнгэр чамайг сахих болтугай.
Хаа ч явсан чамайг
Минийхээс шал өөр сахиус
Дагаж ивээж яваг.
Хүүхэд минь та нар хаа байна?
Ойрт...уухай даа...ахынхаа...гарыг барь.
Очтой байсан нүд минь
Ийм болсон нь миний гай...
Өөрөө би юуг ч...мэдэлгүй...
Аав чинь би...юу ч саналгүй...

Өөрийнхөө...эхээс...та нарыг...төрүүлээ.
Хийсэн лайгаа би эдэлж
Үлдсэн хоногоо өнгөрөөхөд
Та нар надтай байх ёсгүй.
Үрсээ би харахгүй байна.
Дахиад үзэх ч тавилангүй.
Гэлээ ч би өрөвдөөд
Өр минь задчих шахавч...
Яах ч арга алгаа.
Нутгийнхаа олны хэнтэй нь
Сүмд очих вэ та нар минь?
Цэнгэл баярын газар очоод
Гэртээ ирэхдээ инээхгүй,
Уйлах тавиланд учирсныг
Би л хийсэн хэрэг.
Хайр сэтгэлээ нэг хүнд өгч
Ханиа түших нас чинь болохоор
Хэн та нарыг тоох вэ?
Та нарт ирэх үрс болоод
Өөрсдий чинь ингэж бузарласан
Эцгий чинь бодоод хэн ойртох вэ?
Энэнээс илүү зовлон гэж
Хэнд тохиолдож таарах вэ?
Эцэг чинь эцгийгээ хороосон юм.
Төрүүлсэн эхтэйгээ ханилаад
Та нарыг бас төрүүлсэн юм гэж
Үргэлж зэмлэл сонсоно та нар
Охид та нарт минь ханийн заяа
Даанч байхгүй болчив аа даа.
Өнчин үлдээд ханьгүй байх
Тийм хувь бас хэцүү яа?
Менекейн хүү, Креонт чи л
Эднийг энэрэх ганц түшиг нь.
Эцгий нь оронд эцэг бол
Эх бид хоёр нь мөрөө хайж
Энэ хорвоогоос зайллаа.
Хань ижил, гэр оронгүй
Гуйлгачин л битгий болоорой,
Бид хоёрт үр болж төрсөн нь
Эдний буруу биш шүү.

Буруут хоёр нь өөрсдийгөө
Цээрлүүлж зайллаа газар
Сайхан залуу насы нь бод
Чи л эдний түшиг шүү.
Сайн үйлт Креонт чи
Надад тангараглаж үз дээ.
Гараараа эдэнд минь хүр
Хүүхэд минь одоо ч балчир байна
Арай томхон сон бол
Нэлээд... юм хэлмээр байна.
Дээрээс оногдсон хувийн дагуу
Аятай амь зуухыг ерөөе...

Аавд чинь оногдсон бузар заяа
Та нараас холуур тойрох болтугай.

Найрал дуучид

Фиван нутгийн олон минь ээ.
Энэ хэрэг та нарт сургаалтай.
Эдип гэгчийг та нар мэднэ.
Бидний зовлонгийн оньсыг нээж
Сүртэй аюулаас аварсан
Мэргэн ухаант хүн билээ.
Чадал төгс хаан билээ
Эдэнд оногдсон тавилан ерөөл
Атаархам сайхан байсан биш үү.
Гэтэл гэтэлшгүй зовлонгийн далайд
Аймшигт ёроолгүй нүхэнд
Гэв гэнэт унав биш үү?
Ингэхлээр ертөнцийн хүн бүр туж
Хойшхи өдрөө бодох хэрэгтэй.
Зовлон гамшиг гэдгээс
Насан туйл болж авсанд ортлоо л
Эдэлж үзээгүй л болбол
Сая азтай, хувьтай хүн гэж
Санаандаа нэрлэж болдог юм байна.

Төгсөв.

Аристофан

Лисистрата

Орос хэлнээс орчуулсан
Батмөнхийн Энэбиш